

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ,
ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

АЙМАГ БОЛОН СУМДАД ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ЗАРИМ ҮР ДҮНТЭЙ ТАХ-
ҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ЗАХИАЛАГЧИЙН БОЛОН ИТХ-ЫН ТАВИХ
ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙГААГААС ҮҮДЭЛТЭЙ ЧАНАРГҮЙ, ТОО
ХЭМЖЭЭНЭЭС ЗӨРҮҮТЭЙ АЖЛУУД ХИЙГДЭХ ЗӨРЧЛҮҮД ДАВТАН ГАРСААР
БАЙНА

АУДИТЫН КОД: ӨВА-2025/31-14-ШТА-ГА

Өвөрхангай аймаг 2025 он



Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор **О.Батжаргал**

Утас: 7032-3253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер **П.Хорлоосүрсэн**

Утас: 7032-3108 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.mn

Ахлах Аудитор: **Ө.Ринчинмядаг**

Утас: 7032-3833 Цахим хаяг: RinchinmyadagU@audit.gov.mn

Аудитор: **Р.Энхзул**

Утас: 7032-3833 Цахим хаяг: EnkhzulR@audit.gov.mn

Аудитор: **Д.Очирбат**

Утас: 7032-3833 Цахим хаяг: OchirbatD@audit.gov.mn

Аудитор: **Б.Нямсэмжаан**

Утас: 7032-3833 Цахим хаяг: NyamsemjaanB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	5
БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨН, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БОЛОВЧ МТТАТ-ЫН БҮРДҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ЗАРИМ ТАХ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.	7
1.1. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөсөнч Улсын төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 600.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон, МТТАТ-ын он дамжсан авлага сайн буурахгүй байна.	7
1.1.1. ОНХС-ийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийг Сангийн яаманд тооцож байгаа тул орон нутагт үзэх боломжгүй, ОНХС-ийн аудитын нэгдсэн тайланд авч үзнэ.	7
1.1.2. ОНХС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан аргачлалын дагуу хуваарилсан боловч Улсын төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 600.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.	7
1.1.3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгосон ба Хархорин, Уянга, Бүрд, Баянгол сумд өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдэн санхүүжилт нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.	9
1.1.4. Аймаг, сумын ОНХС-д хуульд заасан эх үүсвэрүүдийг төлөвлөсөн боловч МТТАТ-ын авлага жил бүр нэмэгдэж татварын бүрдүүлэлттэй холбоотойгоор сумдад хэрэгжихгүй, он дамнасан ажлууд их байна.	10
1.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн ч иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн зөрчил давтан гаргасаар байна.	12
1.2.1. Өвөрхангай аймгийн 19 сумын 112 багийн иргэдийн саналыг анхан шатанд хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн ч иргэдийн саналгүй ТАХ батлан хэрэгжүүлдэг зөрчил бүрэн арилахгүй байна.	12
1.2.2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан баталсан байна.	16
1.2.3. Аймаг, сумын ОНХС-ийн Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуур хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан байна.	16
1.2.4. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг тусгасан байна.	16
БҮЛЭГ 2. АЙМАГ БОЛОН СУМДАД ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ҮР ДҮНТЭЙ ТАХ-ҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ЗАРИМ СУМ ТӨСВИЙГ ХЭТ ЖИЖИГЛЭН ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ АЖЛУУД ХИЙХ НЬ ТҮГЭЭМЭЛ БАЙНА.	18
2.1. Аймаг, сумууд нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ХАА-нд холбогдох хууль тогтоомжийг бүрэн баримтлаагүй, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгохгүй, чанаргүй ажлуудыг хүлээж авдаг зөрчил давтагдан гарсаар байна.	18
2.1.1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй 13 ТАХ-ний тендер шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.	18
2.1.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч дутуу хийгдсэн, чанаргүй, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй ТАХ-үүдийг хүлээж авсан байна.	22
2.2. Аймаг болон зарим сумдад ОНХС-ийн хөрөнгөөр үр дүнтэй ТАХ-үүдийг хэрэгжүүлсэн боловч сумдад төсвийг хэт жижиглэн үр нөлөө багатай олон ажлууд хийсээр байна.	27
2.2.1. Аймгийн ОНХС-аас зорилтот түвшиндээ хүрсэн иргэдийн аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөл бүрдүүлсэн, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх зарим	

ажлуудыг хийсэн, харин сумдад ТАХ-г ихэвчлэн хэт жижиглэн үр дүн багатай ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна.	27
2.2.2. Аймаг, сумдад орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц үр нөлөөтэй, иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлсэн зарим ажлууд хийгдсэн ба цаашид сумдад ОНХС-аас хэрэгжиж буй ТАХ-үдийн үр нөлөөг сайжруулахын тулд хэт жижиглэн хуваахгүй, хүрэх түвшинг бодитой тодорхойлон, төлөвлөх шаардлагатай байна.	29
2.3. Зарим сумдад ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг бүрэн хүчин чадлаар ашиглахгүй, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байгаа тул аймаг, сумдын ИТХ-с Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хяналтыг тогтмол хийж хэвших шаардлагатай байна.	30
2.3.1. Зарим ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгүүдийг бүрэн хүчин чадлаар ашиглахгүй байгаа бөгөөд камер ашиглалт дээр сумдад сайн анхаарах шаардлагатай байна.	30
2.3.2. Зарим сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалт муугаас, эвдэрч хэмхэрсэн байдалтай байна.	32
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛЖ, ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, МЭДЭЭГ ҮНЭН ЗӨВ ИЛЭРХИЙЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	33
3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавьсан хяналт хангалтгүй байна.	33
3.1.1 Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ түүний үр дүнд тавих хяналтыг тогтмол хийж хэвшээгүй байна.	33
3.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд хийсэн захиалагчийн хяналтын хэрэгжилт хангалтгүй байна.	34
3.1.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт өмнөх гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлсэн боловч алдаа зөрчлүүд давтан гарсан, биелэлт хангалтгүй байна.	36
3.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн тайлангийн мэдээллийн үнэн зөв байдал дутмаг, хөрөнгийг буруу дүнгээр бүртгэх, бүртгэлд огт тусгахгүй байгаа зөрчил давтан гарсаар байна.	38
3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн боловч мэдээллийн үнэн зөв байдал дутмаг байна.	38
3.2.2. ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон 1,011.5 сая төгрөгийн хөрөнгийг буруу дүнгээр бүртгэж, 52.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд огт тусгаагүй байна.	38
3.2.3. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэдэд нээлттэй мэдээлсэн боловч аймаг болон 8 сум мэдээллийг УМС-д дутуу оруулсан, огт оруулаагүй байгаа зөрчил гарсаар байна.	39
3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлсэн байна.	41
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.	42
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ХАРИУ.	43
ДҮГНЭЛТ.	44
САНАЛ.	45
ЗӨВЛӨМЖ.	46
Хавсралт-1.	47
Хавсралт-2.	48
Хавсралт-3.	49
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.	50

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМ	Ашигт малтмал
БИНХ	Багийн иргэдийн нийтийн хурал
БОНХОБТХ	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
МУЗГ	Монгол улсын засгийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОБГ	Онцгой байдлын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУБ	Олон улсын байгууллага
ӨВА	Өвөрхангай аймаг
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТТХ	Татварын тухай хууль
ТШББ	Тендер шалгаруулах баримт бичиг
ТШЗ	Тендер шалгаруулалтын зүйл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ОНХС-ийн орлогын эх үүсвэр сумдаар /мян.төг/	7
Хүснэгт 2. ОНХНС болон улсын төсвөөс 2024 онд Өвөрхангай аймагт хуваарилсан санхүүжилт орлогын төрлөөр /сая.төг/	8
Хүснэгт 3. ОНХНС-ийн санхүүжилтийн сарын хуваарийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/	8
Хүснэгт 4. Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийн хуваарь, хуваарьт	9
Хүснэгт 5. Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийн	10
Хүснэгт 6. Аймгийн ОНХС-аас сумдад олгосон санхүүжилт эх үүсвэрээр /сая.төг/	10
Хүснэгт 7. Аймгийн ОНХС-н бүрдүүлэлтийн төлөвлөгөө	10
Хүснэгт 8. Аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлтийн шатанд иргэдээс санал авсан тоо санал авсан хэлбэрээр	12
Хүснэгт 9. Арвайхээр сумын БИНХ-ын ирцийн тоо	15
Хүснэгт 10. Аймаг, сумын ОНХС-н төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт	16
Хүснэгт 11. Аймаг, сумдын ИТХ-аас 2024 онд ОНХС-ийн ТАХ-нд хяналт хийсэн тоо	34
Хүснэгт 12. Захиалагчийн хяналт	35
Хүснэгт 13. Шилэн дансны зөрчлийг өмнөх онтой харьцуулсан байдал	41
Хүснэгт 14. Шилэн дансны зөрчлийг байгууллагаар харьцуулсан байдал	41

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэл 1. Эх үүсвэрийн эзлэх хувь	8
Дүрслэл 2. ОНХС-ийн төлөвлөлтөд анхан шатанд иргэдээс санал хураалт төрлөөр	13
Дүрслэл 3. Иргэдээс авсан санал асуулга	13
Дүрслэл 4. Иргэдээс авсан санал асуулга	13
Дүрслэл 5. Иргэдээс авсан санал асуулга	13
Дүрслэл 6. Аймгаас 2024 онд иргэдийн саналгүй баталсан төсөл, арга хэмжээ	14
Дүрслэл 7. Аймгийн чиг үүрэг хувиар	17
Дүрслэл 8. Сумын чиг үүрэг хувиар	17
Дүрслэл 9. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан арга - тоо, дүн /сая төг/	18
Дүрслэл 10. ТАХ-ний хэрэгжилт	22
Дүрслэл 11. ОНХС-н харилцах дансны оны эцсийн үлдэгдэл	22
Дүрслэл 12. ИТХ-аас хяналт хэрэгжүүлсэн байдал	35
Дүрслэл 13. УМС-д дутуу оруулсан, огт оруулаагүй ТАХ-ний тоо	39
Дүрслэл 14. Иргэдээс авсан санал асуулга	40

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Бат-Өлзий сумын тендер хянан үзсэн маягт	22
Зураг 2. Арвайхээр суманд хийгдэж буй ЭКО нойл	25
Зураг 3. Зүүнбаян-Улаан сумын 22 айлын орон сууцны засвар	25
Зураг 4. Зүүнбаян-Улаан суманд баригдсан Төрийн албан хаагчийн байр	26
Зураг 5. Бат-Өлзий сумын 3 өргөн чөлөөний зам	26
Зураг 6. Хархорин сумын Орхон багийн төвийн засвар	26
Зураг 7. Эмтийн сайр орчимын урсац тохируулгын усан сан	27
Зураг 8. Арвайхээр сумын холбооны худаг сувагчлал	27
Зураг 9. Уянга сумын хадлангийн зориулалттай их бүрэн трактор	30
Зураг 10. Баянгол сумын ЕБС, СӨББ-н хяналтын камер	31
Зураг 11. Төгрөг сумын хяналтын камер	31
Зураг 12. Хархорин сумын хадлангийн талбай хашиг хашаа	31
Зураг 13. Бат-Өлзий сумын ЭКО нойл	32
Зураг 14. Бат-Өлзий сумын ЕБС хатуу эдлэл	32
Зураг 15. Тарагт сумын СӨББ-н гаднах хүүхдийн тоглоом	32
Зураг 16. Нарийнтуул сумын ЕБС-н хяналтын камер	33
Зураг 17. Хужирт сумын төрийн албан хаагчийн барилга	37
Зураг 18. Хужирт сумын 2-р Цэцэрлэгийн хүнсний агуулах	37
Зураг 19. Хужирт сумын "Хужиртад үйлдвэрлэв төв"-н барилга	37

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит нэр:	Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө
Аудитын код:	ӨВА-2025/31-14-ШТА-ГА
Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 онд баталсан "Аудитын сэдэв батлах тухай" А107, "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт:	“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянасан, тайлагнах эсэх асуудлыг тус тус хамруулна.
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ; Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс; ГХБХБГ, багийн Засаг дарга нарын аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулав. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөв, ажлын тоо хэмжээ, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайланг хамруулан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд судалгаа, шинжилгээ хийсэн.
Аудитад хэрэглэсэн арга зүй:	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын

	шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэлээ.
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:	Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: - Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт; - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; - Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; - Малын тоо толгойн албан татварын тухай хууль; - Төсвийн тухай хууль; - Төрийн хэмнэлтийн тухай хууль; - Төсвийн тогтвортой байдлын тухай хууль; - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль; - Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал”; - Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”; - Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”; - Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”; - Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал хянан удирдаж, аудитын менежер П.Хорлоосүрэн үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ө.Ринчинмядаг, аудитор Р.Энхзул, Д.Очирбат, Б.Нямсэмжаан нар 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 08 дугаар сарын 01-ний өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг анх 13,854.9 сая төгрөгөөр баталсан ба тодотгол хийсэн нэмэлт өөрчлөлтөөр 14,480.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл аймгийн хэмжээнд 3,560.1 сая төгрөг, тайлант онд нийт 16,358.38 сая төгрөгийг төвлөрүүлж, 14,386.9 сая төгрөгийг зарцуулснаар оны эцэст 5,531.57 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Үүнийг аймаг, сумдаар нь задлан харуулбал:

Хүснэгт 1. ОНХС-ийн орлогын эх үүсвэр сумдаар /мян.төг/

Аймаг, сумын нэр	ОНХС-ийн 2024 оны эхний үлдэгдэл	ОНХНС болон улсын төсвөөс	ОН-н өөрийн орлогын бусад эх үүсвэрээс	МТТАТ	Нийт эх үүсвэр	Нийт зарлагын дүн	2024 оны эцсийн үлдэгдэл
Арвайхээр	278,529.1	997,461.8	-	205,146.5	1,202,608.3	1,094,138.6	386,998.80
Баруунбаян-Улаан	81,675.5	287,924.7	-	89,334.2	377,258.9	360,063.2	98,871.19
Бат-Өлзий	244,647.4	1,040,259.5	-	84,878.9	1,125,138.4	716,639.0	653,146.79
Баянгол	156,276.1	237,712.0	-	180,357.9	418,069.9	475,513.4	98,832.60
Баян-Өндөр	64,743.8	434,014.0	-	90,584.8	524,598.8	421,726.1	167,616.50
Богд	365,840.0	709,305.5	-	95,368.5	804,674.0	1,011,418.2	159,095.85
Бүрд	106,967.10	656,451.3	-	101,725.50	758,176.8	764,294.52	100,849.39
Гучин-Ус	111,697.3	556,028.4	-	83,241.3	639,269.7	622,256.5	128,710.48
Есөнзүйл	61,730.7	195,410.8	-	114,093.1	309,503.9	192,647.0	178,587.59
Зүүнбаян-Улаан	8,481.60	247,847.7	-	93,589.00	341,436.7	236,991.88	112,926.42
Нарийнтээл	83,370.1	822,214.1	-	136,698.6	958,912.7	681,734.1	360,548.69
Өлзийт	18,715.3	159,031.0	54,000.0	50,526.6	263,557.6	110,215.0	172,057.86
Сант	247,891.6	233,534.7	9,355.5	129,864.2	372,754.4	445,211.1	175,434.85
Тарагт	174,196.6	324,692.4	-	78,635.6	403,328.0	293,600.9	283,923.62
Төгрөг	261,336.4	666,112.9	-	69,426.6	735,539.5	674,342.8	322,533.16
Уянга	306,050.5	634,285.4	-	106,000.0	740,285.4	511,950.8	534,385.07
Хайрхандулаан	86,136.5	367,227.8	-	124,855.9	492,083.7	478,120.5	100,099.70
Хархорин	204,312.2	365,732.0	-	427,456.9	793,188.9	634,033.4	363,467.66
Хужирт	312,941.1	292,337.4	40,392.5	112,755.4	445,485.3	431,298.1	327,128.30
Аймгийн ОНХС	384,581.5	4,652,511.6	-	-	4,652,511.6	4,230,739.7	806,353.38
Нийт дүн	3,560,120.40	13,880,095.00	103,748.00	2,374,539.50	16,358,382.50	14,386,934.80	5,531,567.90

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ээс ирүүлсэн судалгаа

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 425 ТАХ-нд нийт 23,845.6 сая төгрөг төлөвлөн, баталснаас 326 ТАХ-нд 14,386.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитаар 10,203.6 сая төгрөгийн 43 албан шаардлага; 1,063.5 сая төгрөгийн 67 зөвлөмж өгч; 10,149.49 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 7,830.9 сая төгрөгийн санхүүгийн бус үр өгөөж тооцов.

БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨН, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БОЛОВЧ МТТАТ-ЫН БҮРДҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ЗАРИМ ТАХ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Аймаг, сумдын ОНХНС-ийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөсөнч Улсын төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 600.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон, МТТАТ-ын он дамжсан авлага сайн буурахгүй байна.

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийг Сангийн яаманд тооцож байгаа тул орон нутагт үзэх боломжгүй, ОНХС-ийн аудитын нэгдсэн тайланд авч үзнэ.

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан аргачлалын дагуу хуваарилсан боловч Улсын төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 600.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3¹ дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан

¹ 59.3.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсвөт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

59.3.1.орон нутгийн хөгжлийн индекс;

59.3.2.хүн амын тоо;

59.3.3.хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.3.5.өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ.

“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-д заасны дагуу илтгэлцүүрүүдийг үндэслэн тогтоосон байна. Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр орлогын шилжүүлгийг тооцох аргачлалыг шинэчлэн баталсан.

ОНХНС болон улсын төсвөөс 2024 онд Өвөрхангай аймагт нийт 14,480.8 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөн 13,880.1 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. ОНХНС-аас олгосон санхүүжилтийг эх үүсвэрийг төрөл, задаргаагаар харуулбал:

Дүрслэл 1. Эх үүсвэрийн эзлэх хувь



Хүснэгт 2. ОНХНС болон улсын төсвөөс 2024 онд Өвөрхангай аймагт хуваарилсан санхүүжилт орлогын төрлөөр /сая.төг/

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр - 10%	12,777.3	12,317.1	96.4%
2	Газрын тосны нөөц ашигласны төлбөр - 30%	355.6	266.4	74.9%
3	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр -100%	79.7	79.7	100.0%
4	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр-50%	192.5	141.3	73.4%
5	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ /өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ/	1,075.6	1,075.6	100.0%
ДҮН		14,480.8	13,880.1	95.85%

Эх сурвалж: Сангийн яамны тоон мэдээлэл

Дээрх хүснэгтээс харахад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс олгох санхүүжилт төлөвлөснөөс 460.2 сая, газрын тосны нөөц ашигласны төлбөр 89.1 сая, АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 51.2 сая төгрөгөөр тус тус дутуу олгогджээ.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн хуваарийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. ОНХНС-ийн санхүүжилтийн сарын хуваарийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

Огноо	ОНХНС-ийн орлогын төлөвлөлт		ОНХНС-аас олгосон санхүүжилт	Зөрүү
	Анх батлагдсан	Тодотгол		
1 сар	0	0	-	-
2 сар	1,234.8	1,234.8	1,234.8	0.0
3 сар	1,234.8	1,234.8	1,234.8	0.0
4 сар	1,302.9	1,302.9	1,221.5	-81.3
5 сар	1,234.8	1,234.8	1,232.4	-2.4
6 сар	1,234.8	1,234.8	1,232.6	-2.2
7 сар	1,302.9	1,302.9	1,201.8	-101.0
8 сар	1,234.8	1,234.8	1,198.9	-35.8
9 сар	1,234.8	1,391.2	1,441.9	50.7
10 сар	1,302.9	1,459.3	1,047.8	-411.5
11 сар	1,234.8	1,391.2	1,197.1	-194.2
12 сар	1,302.9	1,459.3	1,636.5	177.2
Дүн	13,854.9	14,480.8	13,880.1	-600.7

Эх сурвалж: Аймгийн СТХС-ийн тоон мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1.²-д заасны дагуу тодотгол хийгдсэн. Дээрх хүснэгтээс харахад 4-8, 10-11 саруудад санхүүжилт тодорхой хэмжээнд хуваариас дутуу олгогдсон бол 8, 12 дугаар саруудад хуваариас илүү олгосон байна. Улсын төсвийн орлогын бүрдүүлэлт, ОНХС-ийн эх үүсвэрийн орлоготой холбоотой 2024 онд нийт 600.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

1.1.3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгосон ба Хархорин, Уянга, Бүрд, Баянгол сумд өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдэн санхүүжилт нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.

Аймгийн ОНХС-аас 2024 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.³-д заасны дагуу, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-д заасан илтгэлцүүрүүдийг үндэслэн хуваарилж, төлөвлөгөөний дагуу санхүүжилтийг сумдад бүрэн олгосон байна.

Хүснэгт 4. Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийн хуваарь, хуваарьт

№	Сумын нэр	Төлөвлөгөө			Сумдад олгосон санхүүжилт
		2024 оны баталсан төсөв	2024 оны төсвийн тодотгол	Тодотголоор нэмэгдсэн дүн	
1	Арвайхээр	959.30	997.46	38.16	997.46
2	Баруунбаян-Улаан	277.11	287.92	10.81	287.92
3	Бат-Өлзий	997.80	1,040.26	42.46	1,040.26
4	Баянгол	226.59	237.71	11.12	237.71
5	Баян-Өндөр	416.73	434.01	17.28	434.01
6	Богд	682.72	709.31	26.59	709.31
7	Бүрд	627.01	656.45	29.44	656.45
8	Гучин-ус	532.79	556.03	23.24	556.03
9	Есөнзүйл	188.03	195.41	7.38	195.41
10	Зүүнбаян-Улаан	238.17	247.85	9.68	247.85
11	Нарийнтээл	787.75	822.21	34.46	822.21
12	Өлзийт	153.00	159.03	6.03	159.03
13	Сант	224.78	233.53	8.75	233.53
14	Тарагт	312.50	324.69	12.19	324.69
15	Төгрөг	638.02	666.11	28.09	666.11
16	Уянга	605.88	634.29	28.41	634.29
17	Хайрхандулаан	353.88	367.23	13.35	367.23
18	Хархорин	348.30	365.73	17.43	365.73
19	Хужирт	281.73	292.34	10.61	292.34
Нийт дүн		8,852.09	9,227.58	375.48	9,227.58

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн СТСХ-ийн тоон мэдээлэл

² 34.2.Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ:

34.2.1. дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон;

³ 59.2.Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна:

59.2.1.энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх;

59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 50-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

59.2.2.1.хүн амын тоо;

59.2.2.2.нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.2.2.3.ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ.

59.2.3.улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6-д заасан хувь хэмжээгээр хуваарилах.

59.2.4. Энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй.

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өссөнтэй холбоотой төсвийн тодотголоор сумдад олгох санхүүжилт өссөн байна.

Хүснэгт 5. Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийн

№	Огноо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	1-р улирал	1,493.34	1,493.34	0
2	2-р улирал	2,430.32	2,430.32	0
3	3-р улирал	2,524.20	2,430.32	-94
4	4-р улирал	2,779.72	2,873.60	94
Нийт дүн		9,227.58	9,227.58	0

Эх сурвалж: Аймгийн CTCX-ийн тоон мэдээлэл

Дээрх хүснэгтээс харахад сумдын 2024 оны санхүүжилтийг хуваарийн дагуу олгосон боловч 3-р улиралд 93.9 сая төгрөгийг дутууг дараа улиралд нөхөн олгожээ.

Хүснэгт 6. Аймгийн ОНХС-аас сумдад олгосон санхүүжилт эх үүсвэрээр /сая.төг/

ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг /19 сум/		Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 100% /6 сум/		Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50% /9 сум/		Урамшуулал /15 сум/		Нийт дүн	
төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц
7,879.8	7,879.8	79.7	79.7	192.5	192.5	1,075.6	1,075.6	9,227.58	9,227.58

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 2023 онд 3 суманд 59.1 сая төгрөгөөр, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 4 суманд 63.7 сая төгрөгөөр төлөвлөн олгож байсан бол 2024 онд тус санхүүжилтүүд нийт 272.2 сая болж сумдад 30-200 хувиар өссөн байна. Мөн өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээгээр 2024 онд 15 суманд нийт 1,075.6 сая төгрөгийн урамшуулал олгогдож Хархорин, Уянга, Бүрд, Баянгол сум урамшуулал аваагүй байна. Тус сумд эх үүсвэрээ нэмэгдүүлэхийн тулд ОНХС-ийн үйл ажиллагаагаа сайжруулах шаардлагатай байна.

1.1.4. Аймаг, сумын ОНХС-д хуульд заасан эх үүсвэрүүдийг төлөвлөсөн боловч МТТАТ-ын авлага жил бүр нэмэгдэж татварын бүрдүүлэлттэй холбоотойгоор сумдад хэрэгжихгүй, он дамнасан ажлууд их байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт заасны дагуу нийт 8 төрлийн эх үүсвэрээс 22,053.96 сая төгрөгөөр төлөвлөсний 65.7 хувь нь ОНХНС болон улсын төсвөөс бүрдэж байгаа бол үлдсэн 34.3 хувь нь орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Боломжит эх үүсвэрүүдийг ОНХС-д нэмж төлөвлөсөн байна. Эх үүсвэрийн төрлөөр харуулбал:

Хүснэгт 7. Аймгийн ОНХС-н бүрдүүлэлтийн төлөвлөгөө

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Эзлэх хувь
1	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг /ТТХ-ийн 60.2.1/	13,132.99	59.5%
2	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр -100% /ТТХ-ийн 60.2.7/	79.72	0.4%
3	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр-50% /ТТХ-ийн 60.2.7/	192.521	0.9%
4	ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	4,061.55	18.4%
5	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр /ТТХ-ийн 60.2.4/	50.0	0.2%
6	Тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг /ТТХ-ийн 60.2.5/	0	0.0%
7	Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ / ТТХ-ийн 60.2.10/	1,075.57	4.9%
8	Бусад орлого / ТТХ-ийн 60.2.9/	79.66	0.4%
9	Малын тоо толгойн албан татвар /ТТХ-ийн 60.2.8/	3,381.95	15.3%
ДҮН		22,053.96	100%

Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэрийн хамгийн өндөр буюу 15.3 хувийг Малын тоо толгойн албан татварын орлого эзэлж байгаа бөгөөд тус эх үүсвэрийг нэмэгдүүлэн төлөвлөж, тайлагнахтай холбоотой /өмнөх оны авлага барагдуулах/ Төрийн аудитын байгууллага болон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дараах зөвлөмж, албан шаардлагуудыг өгсөн. Үүнд:

- ОНХС-ын 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжөөр 1,054.9 сая төгрөгийн бусад авлагыг ОНХС-ийн эх үүсвэрт бүрэн тусгуулан, төлөвлөх,
- Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны хяналт шалгалтаар малын тоо толгойн албан татварын авлагын зөрүү нийт 836.6 сая төгрөгийн авлагыг тайланд тусгуулахаар албан шаардлага өгч 19 сумын санхүүгийн тайланд залруулга тус тус хийгдсэн байна.

Сумын малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлтийн хувь 19 сумын дунджаар 2023 онд 65.4 хувьтай байсан бол 2024 онд 86.6 хувь болж 21.1 хувиар өссөн байна. **/Хавсралт-1 дэлгэрэнгүй хүснэгт харуулав/** Татварын орлогын биелэлт өссөн нь сайн үзүүлэлт боловч 2022 оноос хойш үүссэн нийт 1,376.6 сая төгрөгийн авлага 19 суманд бий болжээ. **/Хавсралт-1 хүснэгтийн 10-р баганын дүнгээс харах/** Малын тоо толгойн албан татварын бүрдүүлэлттэй холбоотойгоор сумдад хэрэгжихгүй, он дамнасан ажлууд их байна. Аймгийн хэмжээнд тус авлагатай холбоотойгоор нэгдсэн арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Бүрд, Баян-Өндөр, Баянгол, Гучин-Ус, Өлзийт, Тарагт, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, Хужирт сумууд ОНХС-ийн эх үүсвэрт МТТ албан татварын авлагыг сумын 2024 төсвийг баталсан ИТХ-ын тогтоолдоо өмнөх оны авлага, тайлант оны ногдуулалтаар салгаж бүрэн тусгаагүй байна.

Сумдын хувьд МТТ албан татварыг бүрдүүлэхтэй холбоотой дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Үүнд:

- БИНХ-аар малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг иргэдэд ил тод мэдээлэх, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулах зорилготойгоор сургалт мэдээллийг хийх. / малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийсэн ажлуудыг тараах материал хэлбэрээр гаргаж малчдад өгч танилцуулах/
- 2022-2024 оны татварын өрийг барагдуулахын тулд малчдын дансыг татварын байцаагч барилт хийж хаасан.
- Малын татвар бүрдүүлэхийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөөгүүр авч явах боломжтой пост машин худалдан авах
- ЗДТГ-аас ажлын хэсэг ажиллах
- албан мэдэгдэл хүргүүлэх

Сумдын хувьд МТТ албан татварыг бүрдүүлэхтэй холбоотой дараах хүндрэлтэй асуудлууд үүсэж байна. Үүнд:

- Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал, малын гаралтай түүхий эдийн үнийн бууралтаас үүдэлтэй малчдын орлого муудах
- Бусад аймагт нутаглан тус сумандаа малаа тоолуулдаг малчид нэлээд байгаагаас татварын бүрдүүлэлт хангалтгүй байх нөхцөл үүсдэг
- Малаа айлд тавьж маллуулдаг. /Мал эзэмшигч нь хотод амьдардаг/
- Хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор малчин болон мал бүхий өрхүүд 7.15, 12.15-ны өдрөөр төлөх ёстой гэж хойшлуулдаг.
- Тэр хүн төлөөгүй байгаа тул манайх төлөхгүй гэсэн дам яриа ихтэй.
- Сумдууд МТТАТ-ын хэмжээг харьцангуй их, бага тогтоодог.

Сумдын хувьд дор бүрнээ тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа ч МТТАТ-ын авлага өссөөр байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

1. МТТАТ-н нийт 1,376.6 сая төгрөгийн авлага 19 суманд бий болсон ба малын тоо толгойн албан татварын бүрдүүлэлттэй холбоотойгоор сумдад хэрэгжихгүй, он дамнасан ажлууд их байна. Иймд аймгийн хэмжээнд тус авлагатай холбоотойгоор нэгдсэн арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.
2. Бүрд, Баян-Өндөр, Баянгол, Гучин-Ус, Өлзийт, Тарагт, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, Хужирт сумд 2024 оны төсөв баталсан тогтоолд ОНХС-ийн эх үүсвэрт-МТТ албан татвараас санхүүжих эх үүсвэрийг төлөвлөхдөө өмнөх оны авлага /өмнөх оны татварын үлдэгдлээс санхүүжих/, тайлант оны албан татвараас санхүүжих дүнг салгаж тусгаагүй байна.

1.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн ч иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн зөрчил давтан гаргасаар байна.

1.2.1 Өвөрхангай аймгийн 19 сумын 112 багийн иргэдийн саналыг анхан шатанд хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн ч иргэдийн саналгүй ТАХ батлан хэрэгжүүлдэг зөрчил бүрэн арилахгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу аймаг, сумын Засаг дарга нар захирамж гаргаж төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх ажлын хэсгийг байгуулж, иргэдээс ирүүлсэн саналыг шат, шатны ИТХ-д танилцуулсан байна.

Аймаг, сумдын иргэдээс анхны санал авах үе шатын талаар

Аймаг, сумдын ОНХС-аас 2024 онд хэрэгжүүлэх ТАХ-ны саналыг авах эхний үе шат дараах байдлаар явагдсан байна. Үүнд:


Хүснэгт 8. Аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлтөийн шатанд иргэдээс санал авсан тоо санал авсан хэлбэрээр

№	Сум, дүүргийн нэр	Саналын тоо /хэлбэр/			Нийт саналын тоо
		Цахим	Бүлгийн ярилцлага	Цаасаар	
1	Аймгийн ОНХС	1,737	-	-	1,737
2	Арвайхээр	2,311	-	17,934	20,245
3	Баруунбаян-Улаан	453	-	1,976	2,429
4	Бат-Өлзий	257	-	4,071	4,328
5	Баянгол	440	-	3,763	4,203
6	Баян-Өндөр	-	-	4,776	4,776
7	Богд	-	-	4,266	4,266
8	Бүрд	124	-	1,651	1,775
9	Гучин-Ус	230	-	5,301	5,531
10	Есөнзүйл	139	-	2,332	2,471
11	Зүүнбаян-Улаан	101	-	4,385	4,486
12	Нарийнтээл	75	-	2,351	2,426
13	Өлзийт	161	-	2,223	2,384
14	Сант	536	-	4,202	4,738
15	Тарагт	230	-	2,609	2,839
16	Төгрөг	164	-	1,979	2,143
17	Уянга	62	-	6,213	6,275
18	Хайрхандулаан	190	-	4,587	4,777
19	Хархорин	201	-	8,897	9,098

20	Хужирт	1,448	0	18,884	20,332
	Нийт дүн	8,859	0	102,400	111,259

Эх сурвалж: ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системийн тоон үзүүлэлт болон аудитын судалгаа
Өвөрхангай аймгийн 19 сумын 112 багын санал асуулгын тоог харахад иргэдээс анхан шатанд саналыг хүртээмжтэй байдлаар авсан байна. Нийт саналын тоог санал хураалтын төрлөөр харуулбал:


Дүрслэл 2. ОНХС-ийн төлөвлөлтөд анхан шатанд иргэдээс санал хураалт төрлөөр



Энэ онд цаасаар санал хураалт өмнөх оноос 3 хувиар буурсан, бүлгийн ярилцлагаар санал хураалт 2,97 хувиар буурсан, цахим санал хураалт 5,9 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа ч аймгийн хэмжээнд ОНХС-ийн санал авах аппликейшн ашиглалт хангалтгүй, уламжлалт цаасан суурьтай санал хураалт их авсан байна.


Аудитын явцад аймаг, сумдын 1513 иргэдээс ОНХС-ийн 2024 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг үндэслэсэн эсэх талаар санал асуулгыг цаасан хэлбэрээр авч Google forms-д санал асуулгыг бүрэн шивж оруулсан. Үүнд:

Дүрслэл 3. Иргэдээс авсан санал асуулга



1. Та 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд саналаа өгсөн үү? гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 591 буюу 39 хувь нь тийм, 922 буюу 61 хувь нь үгүй гэж хариулсан байна.

Дүрслэл 4. Иргэдээс авсан санал асуулга



2. 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг та ямар хэлбэрээр өгсөн бэ? гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 84 буюу 5.5 хувь нь ОНХС-ийн удирдлага мэдээллийн системээр, 230 буюу 15.2 хувь нь гар утасны аппликейшнээр, 277 буюу 18.3 хувь нь багийн иргэдийн нийтийн хурал дээр цаасаар, 922 буюу 61 хувь нь санал өгөөгүй гэж хариулсан байна.

Дүрслэл 5. Иргэдээс авсан санал асуулга



3. Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ? гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 148 буюу 9,7 хувь нь гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олноос, 172 буюу 11,3 хувь нь удирдлагын мэдээллийн системээс, 258 буюу 17,0 хувь нь гар утасны аппликейшн, телевиз, радио, олон нийтийн сүлжээ, 374 буюу 24,7 хувь нь багийн иргэдийн нийтийн хурлаас, 561 буюу 37,3 хувь нь мэдээлэл авдаггүй гэж хариулсан байна.

Дээрх судалгааны дүнгээс харахад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд иргэдийн саналаа өгөх идэвх оролцоо хангалтгүй, ОНХС-ийн талаарх мэдээлэл

хүртээмжгүй зэрэг үзүүлэлтүүд гарсан бөгөөд баг, сумын иргэд эрх зүйн мэдлэггүй, мэдээллээр бүрэн хангаж ажилддаггүйтэй холбоотой байна. Цаашид аймаг, сум, багийн түвшинд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ, удирдлагын мэдээллийн системийн талаарх мэдээллийг иргэдэд сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр хийгдэх ажлыг төлөвлөхдөө “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.4, 7.5, 7.6 дахь хэсэгт заасны дагуу аймгийн Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулаагүй, нээлттэй хэлэлцүүлэг явуулаагүй, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар заасан хугацаанд саналыг хэлэлцүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна. Энэхүү зөрчилд Өвөрхангай аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар зөвлөмж хүргүүлсэн.

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021 оны А/221 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсэг Арвайхээр сумаас 13, Хархорин сумаас 10, Баян-өндөр сумаас 1, Хайрхандулаан сумаас 4, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас ирүүлсэн 43, нийт 67 ажлыг ач холбогдлоор эрэмбэлэн аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 15 ажлын урьдчилсан жагсаалтыг боловсруулсан байна. Тус 15 ажлыг олон нийтэд танилцуулан google form-г ашиглан санал авч 1737 хүн оролцжээ.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр баталсан нийт саналаас иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй аймаг 4 ТАХ, Хужирт сум 1 ТАХ, Арвайхээр сум 2 ТАХ-г баталсан байна. Тухайлбал:

Аймаг ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр эрэмбэлсэн 15 ТАХ-ээс 4 ТАХ-г хасан дараах иргэдийн саналгүй ажлыг баталжээ:

Дүрслэл 6. Аймгаас 2024 онд иргэдийн саналгүй баталсан төсөл, арга хэмжээ



Хужирт сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс:

- Бизнес хөгжлийн төвийн засвар- 37.044 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажлыг иргэдийн санал аваагүй баталсан байна.

Хужирт сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс шинээр худаг гаргах төсөл арга хэмжээнд иргэдийн санал авсан боловч төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ смарт худгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлыг хийсэн ба төсөл арга хэмжээний нэрийг зөрүүтэй байдлаар баталж хэрэгжүүлсэн байгааг цаашид анхаарч ажиллах.

Арвайхээр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс:

- Арвайхээр сум ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлахдаа иргэдийн санал авсан боловч ач холбогдлоор өндөр эрэмбэлэгдээгүй хог тээврийн машин, нийтийн тээврийн автобусны тоог нэмэгдүүлэх; Өндөргэгээн Занабазарын музейн завсарлах, зураг төсөв хийлгэх 2 ажлыг баталсан байна.

Холбогдох хууль, журмын дагуу иргэдийн санал аваагүй ТАХ-г орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталж буй зөрчил бүрэн арилахгүй байна.

Сүмдын БИНХ-аар ТАХ-г хэлэлцэн, эрэмбэлэх үе шат:

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.8-д “Баг, хорооны ИНХ-ын дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хуралдааныг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 6 дугаар сард багтаан зохион байгуулна.” гэж заасан. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д зааснаар БИНХ-ын хүчин төгөлдөр ирц гэдэг нь багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд гурван өрх тутмаас, 400-аас дээш өрхтэй багт таван өрх тутмаас тус бүр нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцдог ба сумдын ИНХ-ын ирцүүд хангалттай байна.

Харин Арвайхээр сумын БИНХ-д оролцсон ирцийг тооцоолон үзэхэд дараах багууд хүчин төгөлдөр ирц хүрээгүй байхад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэн, эрэмбэлж баталсан зөрчил давтан илэрсэн байна. Үүнд:

Хүснэгт 9. Арвайхээр сумын БИНХ-ын ирцийн тоо

№	Сумын нэр	Арвайхээр сум Баг, хороо	2023 оны өрхийн тоо	Хүчин төгөлдөр ирц (400-с дээш 5өрхөөс 1 хүн, 400-с бага 3 өрхөөс 1 хүн)	БИНХ-ын ирц, (иргэний тоогоор)	Ирцийн хувь
1	Арвайхээр	13-р баг, Онги	1101	220	51	23%
2	Арвайхээр	5-р баг, Арвайхээр	1019	204	40	20%
3	Арвайхээр	1-р баг, Согоот	904	181	44	24%
4	Арвайхээр	11-р баг, Хүйс толгой	579	116	85	73%
5	Арвайхээр	4-р баг, Өлзийт	926	185	95	51%
6	Арвайхээр	7-р баг, Дэлгэрэхийн дэнж	642	128	55	43%
7	Арвайхээр	8-р баг, Рашаант	875	175	70	40%
8	Арвайхээр	9-р баг, Бурхи	715	143	40	28%
9	Арвайхээр	2-р баг, Эмт	738	148	48	33%
10	Арвайхээр	12-р баг, Зүлэгт	459	92	43	47%
11	Арвайхээр	10-р баг, Ноён	931	186	82	44%
12	Арвайхээр	3-р баг, Дэлгэрэх	669	134	68	51%
13	Арвайхээр	6-р баг, Ягаантолгой	664	133	101	76%

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

1. Аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр иргэдийн саналд тусгагдаагүй 4 төрлийн 639.28 сая төгрөгийн ажлыг төлөвлөж баталсан байна.
2. Хужирт сумын ОНХС-ийн санхүүжилтээр иргэдийн саналд тусгагдаагүй 37.044 сая төгрөгийн 1 ажлыг төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.
3. Арвайхээр сумын ОНХС-ийн санхүүжилтээр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлахдаа ач холбогдлоор тэргүүнд эрэмбэлэгдээгүй хог тээврийн машин, нийтийн тээврийн автобусны тоог нэмэгдүүлэх; Өндөр гэгээн Занабазарын музейн завсарлах, зураг төсөв хийлгэх нийт 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажлыг баталсан байна.

4. Арвайхээр сумын багуудын ирц хангалтгүй байхад хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэн, эрэмбэлж баталсан байна.

1.2.2. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан баталсан байна.

Өвөрхангай аймаг нь 2024 онд иргэдийн саналаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн 27 төсөл арга хэмжээ, 19 суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 398 төсөл арга хэмжээг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9⁴, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2⁵, 63.3⁶, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.1, 4.3.1, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.14-т заасныг үндэслэн аймаг, сумын орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэмбэлж баталсан байна.

Аймгийн ХБТХОХ-ээс иргэдийн саналаар 2024 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 8,404.079 сая төгрөгийн 26 шинэ ажлыг хийхээр төлөвлөсөн нь Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулсан байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор 2024 онд 19 суманд хэрэгжүүлэхээр нийт 398 төсөл, арга хэмжээг баталсан бөгөөд эдгээр төсөл арга хэмжээг сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан эрэмбэлсэн байна.

1.2.3. Аймаг, сумын ОНХС-ийн Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуур хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.3, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3 дахь заалтуудад ТАХ-ний үндсэн нөхцөлүүдийг заасан. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг ИТХ-д өргөн барьж, батлуулахдаа тухайн шатны Засаг дарга төсөвлөлтийн шаардлагыг хангуулж техник эдийн засгийн үндэслэл зураг, төсөв, эдийн засгийн тооцоо судалгааг хийсэн байх үүрэгтэй. Аймаг, сумын ОНХС-с төлөвлөсөн ажлууд шаардлага хангасан байна.

1.2.4. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2, -т аймгийн түвшинд, 4.4, 4.5-т сумын түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүргийг тус тус заасан. Аймгийн хэмжээнд нийт 425 ТАХ хийхээр төлөвлөснөөс 326 ТАХ хэрэгжүүлж 18,574.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 10. Аймаг, сумын ОНХС-н төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт

Аймаг/Сум	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
19 сумын ОНХС	398	5,391.9	302	11,292.1
Аймгийн ОНХС	27	8,453.8	24	7,282.3
Нийт дүн	425	23,845.6	326	18,574.4


⁴ 6.9.Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

⁵ 63.2.Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэрэгүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

⁶ 63.3.Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн ажлын алба ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлд өргөн мэдүүлнэ.


Сумын ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргийн хүрээнд 12⁷ төрлийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан бөгөөд сумдын ОНХС-ийн төлөвлөлтөөс харахад малын тоо толгойн албан татварын орлогоор хийгдэх ажлыг тусад нь төлөвлөн хууль, журмын дагуу сумын ИТХ-ын тогтоолоор баталсан байна.

Дүрслэл 7. Аймгийн чиг үүрэг хувиар



Дээрх дүрслэлээс харахад аймагт ОНХС-ийн хөрөнгөөр дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээний ажлыг хамгийн их хийсэн бол өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт, ажлын байр бий болгох төрлийн ажлуудыг огт төлөвлөөгүй байна.

Дүрслэл 8. Сумын чиг үүрэг хувиар



⁷ 1.Бэлчээрийн менежментийг сайжруулах;

2.Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/

3.Малын эрүүл мэндийг хамгаалах;

4.Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;

5.Малын чанарыг сайжруулах;

6.Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;

7.Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;

8.Малын тэжээлийн ургамал тариалах;

9.Тэжээлийн нөөц бүрдүүлэх;

10.Байгаль орчныг хамгаалах;

11.Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/;

12.Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа.

Дүрслэл 11-с харахад сумдад ОНХС-ийн хөрөнгөөр малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр хэрэгжүүлэх, орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах ажлыг хамгийн их хийсэн бол өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт хийх ажлыг огт төлөвлөөгүй байна. Сумдад журамд заасан чигт үүрэгт хамааралгүй төлөвлөсөн төсөл арга хэмжээ байхгүй байна.


БҮЛЭГ 2. АЙМАГ БОЛОН СУМДАД ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ҮР ДҮНТЭЙ ТАХ-ҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ЗАРИМ СУМ ТӨСВИЙГ ХЭТ ЖИЖИГЛЭН ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ АЖЛУУД ХИЙХ НЬ ТҮГЭЭМЭЛ БАЙНА.

2.1. Аймаг, сумууд нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ХАА-нд холбогдох хууль тогтоомжийг бүрэн баримтлаагүй, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгохгүй, чанаргүй ажлуудыг хүлээж авдаг зөрчил давтагдан гарсаар байна.

2.1.1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй 13 ТАХ-ний тендер шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

Аймаг болон 19 сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт ТАХ-ээс 2024 онд шинээр нээлттэй тендер шалгаруулах аргаар – 34 /11.15%/, харьцуулалтын аргаар – 101 /33.11%/, шууд худалдан авах аргаар – 170 /55.74%/, нийт 305 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Дүрслэл 9. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан арга - тоо, дүн /сая төг/



Дээрх 305 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэхийг шалгахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 заалтыг зөрчсөн 20 /давхардсан тоогоор 23/ төсөл, арга хэмжээ байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

1. Хуулийн 10.3. “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” заалтыг зөрчиж

- “Аймаг, Орон сууцны гадна фасадын засвар” -н ажил 4-р багц Арвайхээр сум 127-р байр шугамын засвар 9.6 төгрөг, 5-р багц Арвайхээр сум 5, 13, 14-р байр шугамын засвар 19.6 төгрөгийг тус бүр хувааж шууд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан.
- “Төгрөг сумын Тэжээлийн нөөц бүрдүүлэх” 54.0 сая төгрөг 3 хэсэг болж 18.0 сая төгрөгөөр хивэг, 18.00 төгрөгөөр өвс, 18.00 сая төгрөгөөр хүчит тэжээл тус тус шууд худалдан авсан.

- “Өлзийт сумын худгын цооног ухуулах” 45.0 сая төгрөгийн багц ажлыг тус бүр 15.0 сая төгрөгөөр 3 ажил буюу 1, 2, 4-р багт худгийн цооног ухуулах ажил болгож шууд худалдан авалт хийсэн.
- 2. **Хуулийн 12.4. “Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно” заалтыг зөрчиж**
 - “Аймаг, Арвайхээр сумын гудамж талбай, сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны камержуулалтыг нэмэгдүүлэх” ажил дээр Камер бичигчийг JUAN 6216N гэж тухайлан заасан. /332.8 сая төгрөгийн төсөвт/
 - “Төгрөг сум, Сумын лед дэлгэцтэй болох” ажил дээр лед дүрсний дамжуулагчийг NOVA STAR VX6S гэж тухайлан заасан. /68.0 сая төгрөгийн төсөвт/
 - “Тарагт, Гэрэлтүүлэг камертай” ажил дээр камерны загварыг UNIVIEW IPC635SR-X33DU-DT гэж тухайлан заасан. /50.0 сая төгрөгийн төсөвт/
 - “Баянгол сум, ЕБС, СӨББ, Спорт заалны хяналтын камер шинэчлэх” -н бичигчийг JUAN NVR 16 гэж тухайлан заасан. /33.6 сая төгрөгийн төсөвт/
- 3. **Хуулийн 16.6. “Түншлэлийн гишүүн тус бүрийн болон хамтдаа хангавал зохих санхүүгийн чадавхын доод шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана” заалтыг зөрчиж**
 - “Аймаг, Арвайхээр сумын цэцэрлэгт хүрээлэнгүүдэд тохижилт хийх” ажлын баримт бичигт нарийвчлан зааж өгөөгүй, тодорхой бус шалгуур тавьсан. Улмаар Өрнөх мэргэн ХХК -г шалгаруулахад борлуулалтын орлогыг нийлбэр дүнгээр хангаж байна гэж үзээд шалгаруулсан. /900.0 сая төгрөгийн төсөвт/
- 4. **Хуулийн 17.4. “Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна” заалтыг зөрчиж**
 - “Аймаг, Орон сууцны гадна фасадын засвар” -н ажилд 1, 2-р багц Арвайн цамхаг ХХК, 3-р багц Хүүшийн гэгээ ХХК нь тус бүр ТШЗ 19.1.2 /Үндсэн тоног төхөөрөмж, машин механизмийн шаардлага/ -г хангахгүй байхад шалгаруулсан. /489.0 сая төгрөгийн төсөвт/
- 5. **Хуулийн 24.1. “Захиалагч тендер нээсэн даруй тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлж, энэ хуулийн 28.1-д заасан шийдвэрийн аль нэгийг тендер нээснээс хойш ажлын 15 өдрийн дотор гаргана” заалтыг зөрчиж**
 - “Аймаг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд унтуулгын аппарат авах” ажлын шийдвэрийг үнэлгээний хороо 22 хоногт гаргасан. Үнэлгээний хорооны ирц бүрдэхгүй байсан тул 22 хоногт гаргасан ба хүндэтгэн үзэх шалтгаангүй. /80.0 сая төгрөгийн төсөвт/
- 6. **Хуулийн 26.4. “Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ; 26.4.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх. Хуулийн 26.5. Оролцогчийн чадавхын болон туршлагын мэдээлэл төрийн эрх бүхий байгууллагад тайлагнаж баталгаажсан санхүү, нийгмийн даатгалын тайлангийн мэдээлэлтэй нийцсэн эсэхийг хянан үзэж болно” заалтыг зөрчиж**
 - “Аймаг, Арвайхээр сумын авто болон явган хүний зам, гэрэл дохио, гэрэлтүүлгийг засварлах” ажлын 1, 3, 4, 5 -р багцад Хас гарьд ХХК-н хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан шаардлага хангаагүй байхад шалгаруулсан. /931.8 сая төгрөгийн төсөвт/

7. Хуулийн 50.2. “Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 50.2.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, зарлал, урилга боловсруулах, тендер хүлээн авах” заалтыг зөрчиж

- “Аймаг, Арвайхээр сумын авто болон явган хүний зам, гэрэл дохио, гэрэлтүүлгийг засварлах” ажлын 2-р зарлалтаас хурлаар хэлэлцээгүй Машин, механизмын шаардлагыг хассан.
- “Аймаг, Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсийн холбооны худаг сувагчлалын ажил” -н 3-р зарлалтаас хурлаар хэлэлцээгүй Хүний нөөц болон Тоног төхөөрөмжийн шаардлагыг өөрчилсөн.
- “Аймаг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн төрөх, эмэгтэйчүүдийн эмнэлгийн гадна фасадын засвар” -н ажилд Үнэлгээний хорооны хурлаар оролцогчид тавигдах шаардлага, зарлал, урилга хэлэлцсэн тухай хурлын тэмдэглэл байхгүй
- “Сант сум, Майханы арын хүүхдийн тоглоомын талбай” -н ажилд Үнэлгээний хорооны хурлаар оролцогчид тавигдах шаардлагуудыг хэлэлцээгүй. /40.0 сая төгрөгийн төсөвт/
- “Баянгол сум, Ахмадын өргөөний барилгын дотор засвар (Халаалтын шугам, Ариун цэврийн өрөөг тохижуулах)” ажилд оролцогчид тавигдах шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлыг үнэлгээний хороогоор хэлэлцэх байтал нарийн бичигт үүрэг болгосон. /35.0 сая төгрөгийн төсөвт/
- “Зүүнбаян-Улаан сум, 22 айлын орон сууцны засвар” -н ажилд хурлын тэмдэглэлд Санхүүгийн тайланд аудит хийлгэсэн байх гэж хэлэлцсэн боловч цахим системд оруулахдаа хассан. 2-р зарлалтаас хурлаар хэлэлцээгүй Агааржуулалтын бөглөрсөн хэсгийг гаргаж, гадагш гаргах ажлыг хасаж ажлын тоо хэмжээг бууруулсан. /50.0 сая төгрөгийн төсөвт/

8. Хуулийн 52.5. “Энэ хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан дараах үүргийн аль нэгийг хэрэгжүүлээгүй нь түүнийг тухайн худалдан авах ажиллагаатай холбоотой чиг үүргээс чөлөөлж, эрх бүхий этгээд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно: /АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ/” заалтыг зөрчиж

- “Баянгол, Гүн өрмийн худаг шинээр гаргах. Өндөр-Өнц, Хаяа баг” /50,000,000 төгрөгийн төсөвт/
- “Баянгол, Сумын түүхт ойг угтсан бүтээн байгуулалтын ажил”
- “Баянгол, ЕБС, СӨББ, Спорт заалны хяналтын камер шинэчлэх”
- “Баянгол, Ахмадын өргөөний барилгын дотор засвар (Халаалтын шугам, Ариун цэврийн өрөөг тохижуулах)”
- “Зүүнбаян-Улаан, Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, гамшгаас хамгаалах”
- “Зүүнбаян-Улаан, Төрийн албан хаагчдын орон сууц”

Сангийн сайдын 2023 оны А/261 тушаалаар баталсан тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн хавсралт 2 буюу “Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ээр тендерийн баримт бичгээ буруу боловсруулан барааг ажлаар зарласан дараах ТАХ-үүд байна. Үүнд:

- Төгрөг сумын-Суманд лед дэлгэц /68.0 сая төгрөг/, Бохир усны машин /87.6 сая төгрөг/ худалдан авах
- Хужирт сумын Хог тээврийн машин худалдан авах /86.0 сая төгрөг/

Дээрх зөрчлүүдээс үүдэн дараах эрсдлүүд үүсэх магадлалтай байна.Үүнд:

- Худалдан авах барааны загварыг тодотгож өгснөөр тухайн барааг нийлүүлдэг оролцогчид давуу байдал бий болгох /шууд бренд заах г.м/
- Түншлэлээр орж буй оролцогч нарт тавигдах санхүүгийн чадавхийн шаардлагыг нарийн тодорхой зааж өгөөгүйн улмаас санхүүгийн шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулах /ашиг сонирхлын зөрчил/,
- Үнэлгээний хорооны гишүүдийн ажлын ачааллыг тооцоогүйн улмаас үнэлгээний хорооны ирц бүрдэхгүй, шалгаруулалт хуулийн хугацаанаас хэтрэх,
- Үнэлгээний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хурал бөгөөд олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэдэг, гэвч хурлаар оролцогчид тавигдах шаардлагыг хэлэлцдэггүй, ТШББ-г боловсруулж цахим системд оруулахыг нарийн бичигт үүрэг болгодог энэ нь нарийн бичиг дангаар шаардлагыг боловсруулж, оролцогчид давуу байдал бий болгох эрсдэлтэй байна.
- Үнэлгээний хорооны гишүүд хууль, журмын дагуу АЗ-тэй эсэх мэдүүлгийг тухай бүр бөглөхгүй байгаа нь албан хаагчдыг хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх нөхцөл үүсэж байна.

Төсөв бага, ажил их, оролцогч цөөн байдаг учир шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулах тохиолдол байна. Энэхүү нөхцөлөөс хамаарч ажил гүйцэтгэх үед ажлын тоо, хэмжээ өөрчлөгдөх, бараа нийлүүлэх тоо хэмжээ өөрчлөгдөх, хүлээж авах үед хийлгэнэ гэсэн ажил бүрэн биш байх, нийлүүлэх барааны тоо зөрүүтэй, дутуу байхад хүлээж авах тохиолдол байна.

Нийтлэг гарч буй асуудлууд:

- АЗ-тэй маягтыг хугацаанд нь бөглүүлдэггүй.
- Тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулахдаа арифметик алдаа гаргадаг, хуулж тавиад засварладаггүй, хэмжих нэгжийг буруу сонгодог.
- Хурлын тэмдэглэл дээрх болон ТББ дээрх оролцогчид тавих шаардлага зөрүүтэй байдаг.
- Үнэлгээний хороо оролцогчид ямар шаардлага тавих, тухайн ажлыг олон оролцогчтой, өрсөлдөөнтэй болгох, амжилттай зохион байгуулах талаар нарийн сайн ярилцдаггүй.
- Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах нь хариуцлага өндөр, цалин, урамшуулал бага тул гишүүнээр ажиллах албан хаагч, иргэний төлөөлөл олддоггүй.
- Үнэлгээний хорооны ирцээс болж хурал төлөвлөсөн хугацаандаа болдоггүй. Энэ нь нэг хүнд хэт олон ажил өгдөгтэй холбоотой. Нөгөө талаас гишүүд хуулийн 52.2⁸ дахь заалтыг зөрчиж байна.
- Ажлын тоо хэмжээ их эсвэл төсөв хүрэхгүй шалтгаан буюу оролцогч байхгүй, шаардлага хангахгүй оролцогч орж байгаа үед шалтгааныг тодруулж захиалагчид хүргүүлсэн зөвлөмж байхгүй, нотлох баримт байхгүй. Энэ асуудлыг зөвхөн аман байдлаар ярилцдаг.
- Захиалагчаас ажлын тоо хэмжээ ирэхгүй уддаг шалтгаанаар худалдан авах ажиллагаа төлөвлөсөн хугацаандаа зарлагддаггүй.
- Хэмжих нэгжийг буруу сонгодог. Энэ алдаа нь оролцогч тал тендерийн үнийг хэт багаар төсөвлөж ирүүлэх боломжийг бий болгох эрсдэлтэй байна.

Хуулийн 7.1.10. -д /энэ заалтыг 2024 оны 9 дүгээр сарын 15-аас хойш мөрдөнө/ тендерт оролцогчдын ерөнхий шаардлагад Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу хүүхэд хамгааллын төлөвлөгөө гаргасан, тухайн төлөвлөгөөний дагуу ажил хийсэн материал ирүүлэхийг шаардана гэж заасан боловч хэрэгжүүлж ажлаагүй байна. Энэ заалтыг хэрэгжүүлснээр худалдан авах ажиллагаанд оролцогч ажил олгогч, хуулийн этгээд нь байгууллагын дотоод үйл ажиллагаандаа хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлж ажиллах сайн үр дагавартай.

⁸ 52.2.Энэ хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан энэ хуульд зааснаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад цаг тухайд нь оролцох үүрэгтэй.

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/255 дугаар тушаалаар баталсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын хавсралт дахь заавал хөтлөх маягтыг Бат-Өлзий сум тогтмол хөтөлж хэвшсэн ба аймаг, бусад сумд хэвшээгүй байна.

Зураг 1. Бат-Өлзий сумын тендер хянан үзсэн маягт

БАРАА НИЙЛҮҮЛЭХ, АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГОЛЛОХ НӨХЦӨЛ НЬ ШААРДЛАГА ХАНГАХ ЭСЭХИЙГ ХЯНАН ҮЗСЭН ТЭМДЭГЛЭЛ

Тендер шалгаруулалтын нэр: Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Гэрэлтүүлэг засвар, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэгч сонгох шалгаруулах – ӨВАБӨСЗДТГ/20240201004

№	Шаардлага (Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгагдсан голлох нөхцөлийг жагсаан бичнэ)	"Ойш-Од" ХХК	"Засагт ханы өнгө" ХХК
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Тийм	Тийм
2	Төлбөрийн нөхцөл	Тийм	Тийм
3	Тендер шалгаруулалтын баримт бичгийн бусад нөхцөлийг хүлээн зөвшөөрөхгүй тухай илэрхийлсэн эсэх	Үгүй	Үгүй
	Шаардлага хангасан эсэх	Тийм	Үгүй
Шаардлага хангаагүй бол энэ тухай тайлбар			
Эрчим хүчний яамна ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл ирүүлээгүй.			

Үнэлгээний үнэлгээний хорооны гишүүд

Үнэлгээний хорооны дарга:

Б.Пүрэвсүрэн

Н.Орхонтүүл

Үнэлгээний хорооны нарий бичгийн дарга:

Б.Пүрэвсүрэн

Б.Пүрэвсүрэн

Үнэлгээний хорооны гишүүн:

Ж.Алтангэрэл

Ж.Алтангэрэл

ОРОЛЦОГЧИЙН ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ ТЭМДЭГЛЭЛИЙН МАЯГТ

Хүснэгт 1. Тендерийн шаардлагыг урьдчилан хянан үзсэн тэмдэглэл:

№	Шалгуур	"Ойш-Од" ХХК	"Засагт ханы өнгө" ХХК
1	Тендерийг баталгаажуулах, илгээх шаардлагыг хангасан эсэх	Тийм	Тийм
2	Тендерийн шалгаруулалтын баримт бичгийн шаардлага хангасан эсэх	Тийм	Тийм
3	Оролцогч шаардлага хангаж эсэх	Тийм	Тийм
4	Баруун гарал үүсэл тодорхой эсэх (хөдөөн дотоодын баруун худалдан авах бичиг хуудас харгалзан)	Тийм	Тийм

Хүснэгт 2. Оролцогчийн шаардлага хангах эсэхийг хянан үзсэн тэмдэглэл

№	Шалгуур	"Ойш-Од" ХХК	"Засагт ханы өнгө" ХХК
1	Боломж нөхцөлийг хангаж эсэх	Тийм	Тийм
2	Гэрээний этгээд оролцогчийн тендер шалгаруулалт ажиллагаа гэрээний этгээд тендер ирүүлсэн эсэх	Үгүй	Үгүй
3	Диндэр ажил үйлчилгээ оролцож байгаа эсэх	Дангараа	Дангараа
4	Түншлэл бол гэрээ шаардлага хангаж эсэх	Тийм	Тийм
5	Зөвхөн нэг тендер ирүүлж шаардлагыг хангасан эсэх	Тийм	Тийм
6	Тендер шалгаруулалтад оролцох эрхээ илгээжүүлсэн этгээдийн жагсаалтад байгаа	Тийм	Тийм
7	Чадварын шаардлага хангасан эсэх	Тийм	Тийм
8	Шаардлага хангасан эсэх	Тийм	Тийм
9	Тэмдэглэл	Шаардлага хангасан тендер ирүүлсэн.	Эрчим хүчний яамна ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл ирүүлээгүй.

Үнэлгээний үнэлгээний хорооны гишүүд

Үнэлгээний хорооны дарга:

Б.Пүрэвсүрэн

Н.Орхонтүүл

Үнэлгээний хорооны нарий бичгийн дарга:

Б.Пүрэвсүрэн

Б.Пүрэвсүрэн

Үнэлгээний хорооны гишүүн:

Ж.Алтангэрэл

Ж.Алтангэрэл

ХАМГИЙН САЙН ТЕНДЕРИЙН МЭДЭЭЛЭЛ

1

Хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогч (гэрээ байгуулах эрх олгохоор санал болгож буй).

"Ойш-Од" ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо Ажилчдын гудамж "Ойш-Од" ХХК

1.1.

Нэр

"Ойш-Од" ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо Ажилчдын гудамж "Ойш-Од" ХХК

1.2.

Хаяг

Байгалийн 1

Дангараа 2

China 3

Түншлэл бол, гишүүн бүрийн нэр,

3 улс, болон гэрээний гүйцэтгэлийг хариуцах хувийг

жагсааж,

Гэрээнд гарын үсэг зурахаар

5 тооцогдсон өдөр (он, сар)

6 Буюу гүйцэтгэх) дуусах тооцогдсон хугацаа

7 Тендерийн зарлагдсан үнэ

8 Загваруулсан

9 Үнийн хөнгөлөлт

10 Бусад тохируулга

11 Гэрээний санал болгосон үнэ

Байгалийн 1

Дангараа 2

China 3

2024.06.01

2024.06.30

Дүн 37,805.139

Хувь

0.0

0.0

0.0

37,805.139

Үнэлгээний үнэлгээний хорооны гишүүд

Үнэлгээний хорооны дарга:

Б.Пүрэвсүрэн

Н.Орхонтүүл

Үнэлгээний хорооны нарий бичгийн дарга:

Б.Пүрэвсүрэн

Б.Пүрэвсүрэн

Үнэлгээний хорооны гишүүн:

Ж.Алтангэрэл

Ж.Алтангэрэл

2.1.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч дутуу хийгдсэн, чанаргүй, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй ТАХ-үүдийг хүлээж авсан байна.

Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор нийт 23,845.6 сая төгрөгийн 425 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөн өмнөх оноос дамжин орж ирсэн болон шинэ оны 326 ТАХ-нд 18,574.4 сая төгрөгийн гэрээ байгуулсан. ТАХ-ний хэрэгжилтийн төрлөөр харуулбал:

Дүрслэл 10. ТАХ-ний хэрэгжилт

	Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ
Тоо	283	43	99
Гэрээний дүн	10,889.9	7,684.5	4,182

Дээрх графикаас харахад нийт 425 ажлаас 66.6 хувь нь бүрэн хэрэгжсэн, 10.1 хувь нь дутуу хэрэгжсэн, 23.3 хувь нь огт хэрэгжээгүй байна.

Огт хэрэгжээгүй ТАХ шалтгаан- ХАА зарлаад 2-8 удаа зарлаад оролцогч байхгүй, малын тоо толгойн албан татвар дутуу төвлөрсөн, зарим нэг төлөвлөлтийн асуудалтай холбоотой (хийгдэх ажил тодорхойгүй, дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй байхад төлөвлөх); дутуу хэрэгжсэн ТАХ шалтгаан – сайжруулах шаардлагатай тул хүлээж аваагүй, ХАА олон зарлагдан оны эцсээр гэрээ байгуулагдан хүйтний улирал таарсан тул ажлын чанарт нөлөөлнө гэж үзэх, 2023 оноос дамжиж ирсэн Шүүхэд шилжсэн тул дутуу хүлээж аваагүй. Эдгээрээс шалтгаалан харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн байдалтай байна.

Дүрслэл 11. ОНХС-н харилцах дансны оны эцсийн үлдэгдэл



Төсвийн тухай хууль 60 дугаар зүйлийн 60.3⁹, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан **ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахыг зөвшөөрөхгүй буюу зориулалт бус дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:**

- Арвайхээр суманд хийгдсэн 693.0 сая төгрөгийн Эко 00 төсөл хэрэгжүүлэх ажил- нийт 11 баг 200 ш эко нойл иргэдээс тодорхой зардлыг гарган-иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэгийн шинжтэй /нийт 446.5 сая төгрөгийн санхүүжилт олгосноос- аймгийн ОНХС-с 279.3 сая төгрөг олгосон нь бодит гүйцэтгэлээр санхүүжээгүй зөрчлөөр, Арвайхээр сумаас 167.2 сая төгрөгийг олгосон чанаргүй ажил гүйцэтгэсэн зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлсэн/
- Богд суманд хийгдсэн 30.0 сая төгрөгийн Морины их шүтээний засвар, талбайн тохижилт ажил-хөшөө, дурсгалын шинжтэй

Батлагдсан ТАХ хэрэгжүүлэхдээ иргэдийн саналгүй ажлыг дотор нь шингээн хийх тохиолдлууд байна. Үүнд:

- Богд сумын Ус сувгийн их засварын ажлаас / зорилтот түвшин: сумын төвийн ундны усны хэрэгцээ сайжирна/ ЗДТГ нь 18.9 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж
- Хайрхандулаан сумын Сургуулийн үдийн цайны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, сайжруулах ажлаас сумын цэцэрлэгт 7.0 сая төгрөгийн дроз дэвсгэр тус тус худалдан авсан.

Гэрээнд заасан хугацаандаа хийгдээгүй, дутуу ажлууд:

- Хайрхандулаан суманд Нийтийн амралт хүндэтгэлийн талбайтай болох ажил Далайгүүр ХХК хийж гүйцэтгэж буй 72.3 сая төгрөгийн ажил дуусаагүй
- Бат-Өлзийн суманд "Хутагт- уулын өгөөж" ХХК хийж гүйцэтгэж буй 2 худгийн ажил 69.0 сая төгрөг тус компанийн тоног төхөөрөмж эвдэрсэн гэх шалтгаанаар ажил удааширсан
- Сант суманд ИЛЧ КАССАНДРА ХХК хийж гүйцэтгэж буй Гэр хороолол руу дулааны шугам оруулах 291.7 сая төгрөгийн ажил хийгдэж дуусаагүй
- Аймгийн ОНХС-аас Өрнөх мэргэн ХХК хийж гүйцэтгэж буй 71.0 сая төгрөгийн Туурийн хамгаалалтын хашааны ажил 2022 оны 09 дүгээр сараас хойш хийгдэж буй ажил
- Уянга сумын 5-р багийн Ногоон булгийн эхэнд худаг гаргах ажил 18.6 сая төгрөгийн ажил Аум алт ХХК хийж гүйцэтгэсэн нэг насос дутуу хүлээлцээгүй, дуусаагүй байна.

Гүйцэтгэлээр санхүүжээгүй ажлууд:

- Арвайхээр суманд хийгдсэн 693.0 сая төгрөгийн Эко нойлын ажил-бодит байдал дээр 38 хувийн гүйцэтгэлтэй буюу 266 эко нойл хийхээс 102-г хийсэн байхад 64 хувийн санхүүжилт болох 446.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Арвайхээр сумын цэцэрлэгт хүрээлэнгүүдэд тохижилт хийх 896.0 сая төгрөгийн ажил- бодит байдал дээр 60 хувийн гүйцэтгэлтэй байхад 725.96 сая төгрөг буюу 80%-н санхүүжилт олгосон
- Бат-Өлзийн суманд хийгдсэн Наадмын талбайн засвар, 2 давхар болгох, наадмын талбай руу тог татах 188.8 сая төгрөгийн ажил хийгдэж дуусаагүй байхад бүрэн санхүүжилт өгсөн.
- Богд суманд хийгдсэн Сумын төвийн гэр хорооллын тохижилт хаягжуулалтын 45.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй байхад хүлээн авсан. /хаягжуулалтын бүртгэл бүрэн хийгдээгүй гэсэн шалтгаанаар хойшилсон-Хаягжилт хийгдэхгүй байгаа шалтгаан нь

⁹ 60.3.1.орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.

60.3.2.улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага;

60.3.3.үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;

60.3.4.нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;

60.3.5.зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;

60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас хаягжилтын мэдээлэл гарах боломжгүй байгаа тул, төлөвлөлтийн алдаанаас мөн шалтгаалсан/

Техникийн тодорхойлолтоос зөрүүтэй ажлууд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн Төв бараан захын авто зам шинэчлэл 209.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын явган хүний зам тоо хэмжээ зөрүүтэй. /Хас гарьд ХХК/
- Баянгол сумын ЭМТ-н шүдний кабинет тохижуулах 19.8 сая төгрөгийн ажил шүдний сандлын үзүүлэлт хүчин чадал, даац зөрүүтэй /ДӨРВӨН САЙХАН МЕД ХХК/
- Төгрөг сумын Спортын талбай тохижуулах 126.9 сая төгрөгийн ажил нийтийн бие засах 1 шээлтүүр, 2 гар угаалтуур дутуу; цонх 60*60 байхаас 40*80 тай байсан; сур харваа 10-15 см цутгалттай байхаас 6 см, хайсан хашаа өндөр зөрүүтэй /Баянсувд-Эрдэнэ ХХК/
- Уянга сумын Нийтийн ариун цэврийн газар байгуулах 79.5 сая төгрөгийн ажил зургаас зөрүүтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өрөө стандартын бус. /Девсофт ХХК/
- Хайрхандулаан сумын Цахим сургалт, мэдээллийн өрөө тохижуулах ажил нийлүүлэгдсэн тоног, төхөөрөмжийг тулгахад өндөр нягтралтай “Хурлын камер” байхгүй.
- Төгрөг сумын төвийн камер, гэрэлтүүлгийн 83.9 сая.төг төсөвтэй ажлын даалгаварт 1-р үе 20см-с багагүй, 2-р үе 13см-с багагүй байх байх 10 метр өндөр 2 толгойтой гэрэлтүүлгийн 20 ширхэг шон байршуулах, хяналтын камер суулгах дээрх хэмжээтэй адил 12 ширхэг шон байршуулах ажил хийхээр төлөвлөсөн. Бодит байдал дээр 1-р үе 10см, 2-р үе 7см хийгдсэн байхад хүлээж авсан. Хүчтэй шуургатай үед гэрлийн болон камерын шон хэт их хөдөлгөөнтэй байдаг. Хяналтын камер шүүж үзэх боломжгүй болдог байна.Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 30ш камер ажиллах ёстойгоос 4ш камер ажиллаж байна. Ажиллахгүй байгаа камеруудын шалтгааныг тодруулаагүй. /Баянсувд-Эрдэнэ ХХК/
- Нарийнтээл сумын Өндөр хөмөг багийн төвийг засварлах 32.0 сая төгрөгийн ажилд Сагс, волейболлын талбайг 30м урт, 18м өргөн, 10см-с багагүй зузаантай байх цутгах гэж заасан боловч тулгалтаар үзэхэд 30м урт, 9м өргөн, 5см зузаантайгаар буюу цутгалтын ажлы 25%-тай хийсэн байна. Хүлээж авах комисс техникийн шаардлага бүрэн хангасан гэж үзээд хүлээж авсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний налуу замыг стандартын бус хийсэн. /Арвайн хийц ХХК/
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй 71.0 сая төгрөгийн Туурийн хамгаалалтын хашааны ажил техникийн тодорхойлолтоос зөрүүтэй- шон дутуу, шон хоорондын зай зөрүүтэй, чанаргүй материалаар хийсэн, хийгдсэн хэсэг нь эвдэрсэн. /захиалагч Дэлхийн Өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаанаас гүйцэтгэгчид удаа дараа шаардлага тавьсан боловч биелүүлээгүй ажил удааширсан/

Чанаргүй хийгдсэн ажлууд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн Арвайхээр сумын Авто замын уулзварын өргөтгөл хийх Хас гарьд ХХК гүйцэтгэсэн 350.0 сая төгрөгийн ажил ус зайлуулалт шийдээгүй ус их хэмжээгээр тунасан.
- Арвайхээр суманд хийгдсэн Отгоннинж ХХК-ийн хийж гүйцэтгэж буй 693.0 сая төгрөгийн Эко нойлын ажил суурилуулсан боловч газарт суулт өгсөн, хаяавч шороо цөмрөлттэй, бэхэлгээ муу тул зарим 00 дээд бүхээг салхинд унаж салсан, нойлын нүх ухан орхиж дээд бүхээг хийхгүй удсанаас иргэдэд хүндрэлтэй, эрсдэлтэй байдал үүсгэсэн.

Зураг 2. Арвайхээр суманд хийгдэж буй ЭКО нойл



- Арвайхээр суманд хийгдсэн 44.9 сая төгрөгийн Ногоон байгууламж нэмэгдүүлэх торон хайс чанар муутай хийгдсэн
- Арвайхээр суманд хийгдсэн 7 багийн 6 Хүүхдийн тоглоомын талбай засварлах, тохижуулах Мандах төгс гурван эрдэнэ ХХК хийж гүйцэтгэсэн 77.3 сая төгрөгийн ажил засварын хугацаа сунгаснаас үүдэлтэй эхний хийгдсэн зүйлс эвдрэл үүсэж эхэлсэн.
- Тарагт суманд хийгдсэн Наадмын талбай барих Ткон констракшн ХХК хийж гүйцэтгэсэн 143.9 сая төгрөгийн ажил саравчууд бэхлэгээ болон чанар муу, 8 лэд гэрэл хийгээгүй, төв асрын урдах төмөр хашлага байхгүй, төв асар болон үзэгчдийн асрын материалыг өөрчилсөн.
- Хужирт суманд хийгдсэн Соёлын төвийн урлагийн хувцас, техник шинэчлэх Шикдеко ХХК хийж гүйцэтгэсэн 45.0 сая төгрөгийн ажлаас 14.65 сая төгрөгийн бүжгийн хувцас чанар байдал муу
- Бат-Өлзий сумын Наадмын талбайн засвар, 2 давхар болгох, наадмын талбай руу тог татах Есөн бор - Өндөр ХХК хийж гүйцэтгэсэн 188.8 сая төгрөгийн ажил чанар байдлын хувьд муу /угаадаг замаск хууран урссан, том асрын тулгуур төмөр дутуу, 2 давхрын шал төмөр шал хийх байсныг модоор хийсэн/
- Богд сумын Дотуур байрны хатуу зөөлөн эдлэл нийлүүлэх, засварын ажил Баянховд ХХК хийж гүйцэтгэсэн 103.97 сая төгрөгийн ажлаар нэмэлт гэрээгээр 13.0 сая төгрөгөөр 2 байранд дүш хийгдсэн бөгөөд шугам бөглөрөн дүшний ус доошоо алдан тааз, хана нэвчсэн.
- Зүүнбаян-Улаан сумын 22 айлын орон сууцны засвар Сод-Ээл ХХК хийж гүйцэтгэсэн 49.8 сая төгрөгийн ажлаар дээврийн ажил дутуу хийгдсэн тамбар будаг урссан, дээвэр дээрх олон жил борооны усанд норж дагтаршсан дулаалгын хэсгийг бүрэн хатаахгүйгээр дээврийг сольсон тул айлуудын таазнаас дусаал гоождог хэвээр, тамбарын будаг урсаж, дусаал гоожсон, дээврийн унь модыг банзаар битүүлэх ажил хийгдээгүй байна.

Зураг 3. Зүүнбаян-Улаан сумын 22 айлын орон сууцны засвар



- Зүүнбаян-Улаан сумын Төрийн албан хаагчдын орон сууц Бага хайлантай ХХК хийж гүйцэтгэсэн 142.7 сая дээвэр цантдаг үүнээс шалтгаалан тааз ус гоождог, дотор цуурал өгсөн, цонхоор шороо их ордог, гадаа хаяавч хийгдээгүй, агааржуулалт муу, бохирын кольцоог байшингийн өндөр талд суулгасан тул бүрэн дүүргэх боломжгүй.

/дээврийн дулаалгын талаар ажлын даалгавар тусгаагүй тул дулаалга муу, агааржуулалтын шийдэл буруу хийгдсэн тул дээвэр хэсгээр дулаан их алддаг, агааржуулалтын хоолойноос ус дусдаг, дээвэр цантаж дусаал гоождог, дотор ханад цуурал өгсөн, цонх хаалттай, гадна салхитай үед шороо их ордог, гадаа хаяавч хийгээгүй, бохирын кольцоог байшингийн өндөр талд суулгасан, бохирын хоолойг хамгийн дээд талын биш дунд талын кольцод холбосон тул бүрэн дүүрээгүй байхад соруулах шаардлагатай болдог асуудалтай. Ажлын даалгавар дээр 100м гүний худаг өрөмдөж насос тавих ажил байсныг өөрчилж төвийн цэвэр усны шугамд холбосон. Энэ хэсгийн ажилд төсвийн хэмнэлт гарч байна./

Зураг 4. Зүүнбаян-Улаан суманд баригдсан Төрийн албан хаагчийн байр



- Гучин-Ус сумын Ахмадын өрөөг засварлах Их угалз ХХК 8.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн дээврээс ус гоожсон асуудал шийдэгдээгүй, дусаал гоожсон байдалтай байна.
- Бат-Өлзий сумын 3 өргөн чөлөөний зам засах ажил Анда Рөүд ХХК хийж гүйцэтгэсэн нийт 798.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй /сумын ОНХС-аас 400.0 сая төгрөг төсөвлөсөн/ чанар муу. Зам дээр ус их хэмжээгээр тогтдог, олон тооны нүх үүссэн, гэрээний хугацаандаа дуусгаагүй, хүлээж аваагүй байна.

Зураг 5. Бат-Өлзий сумын 3 өргөн чөлөөний зам



- Хархорин сумын Орхон багийн төвийн барилга засварлах ажил 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Б.Лхагвадорж хийж гүйцэтгэсэн техникийн шаардлага хангаагүй, чанаргүй хийгдсэн байхад ажлыг хүлээж авсан. Паркетин шал хийгдсэн боловч хөөрч, нумарсан, дээвэрт ОСП хавтангаар дотор дээвэрлэлт хийх байсан боловч дутуу хийсэн, өргөтгөж барьсан хананы дагуу ус, дусаал гоождогоос болж ашиглах боломжгүй байна.

Зураг 6. Хархорин сумын Орхон багийн төвийн засвар



- Есөнзүйл сумын ОНХС-ийн хөрөнгөөр Хөдөлмөр зуслан вэб сайт хийх 5.0 сая төгрөгийн ажил хийгдсэн ажил тодорхойгүй. /www.nomadiceducation.mn мэдээлэл оруулсан гэх боловч нотлогдоогүй/

МУЗГ-ын 2010 оны 271 дүгээр "ЖИШИГ ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ (наадмын санхүүжилт)" тогтоолоор Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтооно гэж заасан. Гэвч ОНХС-аас аймаг 55.1 сая, Нарийнтээл сум 14.9 сая, Гучин-Ус сум 14.6 сая төгрөгийг баяр наадмын зардалд зарцуулсан байна.

2.2. Аймаг болон зарим сумдад ОНХС-ийн хөрөнгөөр үр дүнтэй ТАХ-үүдийг хэрэгжүүлсэн боловч сумдад төсвийг хэт жижиглэн үр нөлөө багатай олон ажлууд хийсээр байна.

2.2.1. Аймгийн ОНХС-аас зорилтот түвшиндээ хүрсэн иргэдийн аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөл бүрдүүлсэн, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх зарим ажлуудыг хийсэн, харин сумдад ТАХ-г ихэвчлэн хэт жижиглэн үр дүн багатай ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийт 10,889.9 сая төгрөгийн 283 ТАХ-г бүрэн хэрэгжсэн байна.

Аймгийн ОНХС-аас 2024 онд хийгдсэн зорилтот түвшиндээ хүрсэн ажлууд:

- “Арвайхээр сумыг үерээс хамгаалах зорилгоор Эмтийн сайр орчимд урсац тохируулгын усан сан байгуулах ажлыг эхлүүлэх” Хайдродизайн прожект ХХК хийж гүйцэтгэсэн 1.35 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлаар ус хуримтлуулах боомтыг байгуулснаар нийт 1.2га газарт 33350.40м³ үерийн усыг хуримтлуулж, Арвайхээр сумын 1, 2, 7, 5 дугаар багийн 3392 айл өрхийн 20.0 мянга орчим иргэдийн аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөл бүрдсэн.

Зураг 7. Эмтийн сайр орчимын урсац тохируулгын усан сан



- “Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсийн холбооны худаг сувагчлалын ажил” Нанар ХХК хийж гүйцэтгэсэн 189.4 сая төгрөгийн ажил нь шинэ суурьшлын бүсийн айл өрх, албан байгууллагууд интернэтийн болон харилцаа холбооны үйлчилгээг авах нөхцөл байдлыг бүрдүүлсэн, дэд бүтэц талаас оновчтой шийдэл бүхий ажил болсон байна. Тус дэд бүтцийн асуудлыг цогцоор шийдэх ажлыг үргэлжлүүлэн хийх шаардлагатай бөгөөд өндөр ач холбогдолтой ажил юм.

Зураг 8. Арвайхээр сумын холбооны худаг сувагчлал



Аймгийн ОНХС-аас 2024 онд хийгдсэн зорилтот түвшиндээ хүрээгүй ажлууд:

- Аймгийн “Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Арвайхээр сумын гэр хорооллын айл өрхүүдэд нийлүүлэх сайжруулсан шахмал түлшний үнийн зөрүү олгох” 340.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил нь Агаарын бохирдол буурч 35725 иргэнд өгөөжөө өгнө гэсэн төлөвлөлттэй байсан боловч зорилтот түвшиндээ хүрээгүй. Мөн анхан шатны баримт, тооцоо, судалгаа, тайлан бүрэн бус байхад “Баянтээг түлш” ХХК-н санхүүжилт хүссэн албан тоотыг үндэслэл болгон шилжүүлэг хийсэн.
- Уянга сумын 2023 оны Хадлангийн зориулалттай иж бүрэн техник, тоног төхөөрөмж худалдан авах / төсөв 60.62 сая.төг/ ажлын трактор иж бүрдлээр ирсэн тоног, төхөөрөмжөө дийлдэггүй. Тухайн тоног, төхөөрөмжүүдийг хүлээн авснаас хойш зөвхөн нэг иргэнд сарын 100.0 мянган төгрөгөөр түрээсэлж байна. Тус ажил нь Өвсний нөөц бүрдэж өвсний үнэ хямдарна гэсэн төлөвлөлттэй байсан боловч зорилтот түвшиндээ хүрээгүй.

Төсөл хэрэгжүүлснээр шийдвэрлэгдэх асуудал, гарах үр дүнг илүү нарийвчлан тодорхойлох хэт том, өргөн хүрээтэй тодорхойлсноор зорилтот түвшиндээ хүрэхгүй байх, хийгдэх ажил тодорхой биш байх нөхцөл бүрдэж байна. Иймд хүрэх түвшинг тодорхойлохдоо асуудлыг хэсэгчлэн болон бүрэн шийдвэрлэх эсэхийг тодорхой оновчтой, хэмжиж болохуйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц байдлаар оруулах шаардлагатай юм.

Дэд бүтэц бүрэн шийдэгдээгүй байхад хийгдсэн ажлууд:

- Уянга сум-Шугам сүлжээний ажил бүрэн хийгдээгүй байхад баригдсан “Нийтийн ариун цэврийн газар байгуулах” 79.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил
- Баянгол сум-Тог цахилгааны асуудал шийдэгдээгүй байхад баригдсан “Баянгол суманд мал нядалгааны цех байгуулах ажил” 79.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил
- Сант сум-Усан хангамж хангалтгүй байхад хийгдэж буй “Гэр хороолол руу дулааны шугам оруулах” 291.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил /албан шаардлага/
- Тарагт сум-Тог цахилгааны асуудал шийдэгдээгүй байхад гэрэлтүүлгүүд хийгдэхээр заасан Тарагт сумын “Наадмын талбай барих зураг төсөл” 150.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил
- Нарийнтээл сум-Инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж дуусаагүй байхад баригдсан “Төрийн албан хаагчдын орон сууц” 188.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил /шугамын ажил 2026 онд ашиглалтад орохоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байна/

Дэд бүтцээ шат дараатай шийдэн хийгдсэн ажлууд:

- Богд суманд баригдсан 190.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Нийтийн халуун ус барих ажил
- Төгрөг суманд хийгдсэн 126.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Спортын талбай тохижуулах ажлаар хийгдсэн нийтийн нойлын ажил
- Зүүнбаян-Улаан суманд баригдсан 142.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Төрийн албан хаагчдын орон сууц.

Дэд бүтцийг шийдээгүйгээс үүдэлтэй ашиглалтад орох хугацаа хойшлох, иргэдэд үр өгөөжөө өгөхгүй, ашиглалтгүй хөрөнгө үүсэх эрсдэл үүсэж байгаа бол шат дараатайгаар дэд бүтцээ шийдэн цогц байдлаар төлөвлөсөн ажлууд ашиглалт сайн байх давуу талтай байна. Иймд ТАХ-ний үр ашиг, үр дүнг сайжруулахын тулд цогц байдлаар төлөвлөлт, судалгааг хийх нэн шаардлагатай байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг 15 суманд 560.5 сая төгрөгийг төлөвлөн 526.4 сая төгрөгийн малын тэжээлийн үр, хорголжин, өвс, ногоон тэжээл, улаан буудай, хивэг бэлтгэсэн байна. Аймгийн Онцгой комиссоос сум бүрд малын тоо тоотой уялдуулан төлөвлөгөөт тоог заан шаардлага тавьдаг, 2024 онд өвөлжилт

хүндрээгүй тул өвс тэжээлийн үлдэгдэл их байгаа бөгөөд үүнтэй холбоотой өвсний үнэ бууран сумууд өвсөө авсан үнээсээ маш бага үнээр худалдах нөхцөл байдал үүссэн байна. Их хэмжээний нөөц үүсэн удаан хугацаанд хадгалснаар муудаж үр дүнгүй ажил болох эрсдэлтэй байна.

Тухайлбал: Богд сумын хувьд 3000 боодол ногоон тэжээл, 1600 шуудай орос хивэг нөөцлөн бэлтгэснээс нийт 35.6 сая төгрөгийн 2000 боодол өвс хөгцөрч харлан муудсан /ногоон тэжээл өвөл хөлдүү, нойтон ирдэг/ байдалтай байна.

Иймд өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлт дээр аймгаас нэгдсэн арга хэмжээ авах, сумууд хадгалалтын горимтой уялдуулан нөөц бэлтгэх зэрэгт анхаарах шаардлагатай байна.

2.2.2. Аймаг, сумдад орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц үр нөлөөтэй, иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлсэн зарим ажлууд хийгдсэн ба цаашид сумдад ОНХС-аас хэрэгжиж буй ТАХ-үдийн үр нөлөөг сайжруулахын тулд хэт жижиглэн хуваахгүй, хүрэх түвшинг бодитой тодорхойлон, төлөвлөх шаардлагатай байна.

Аймаг, суманд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ээс орон нутгийн хөгжилд үр өгөөжөө өгсөн, иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлсэн дараах ажлууд байна. Үүнд:

Аймаг болон сумдад хийгдсэн камержуулалт- Камержуулалтын ажлууд хийгдсэнээр гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон илрүүлэхэд сайн нөлөөтэй байна. /камерын нягтаршил чанар зэрэгт анхааран мэргэжлийн байгууллага болох Цагдаагийн газраас нэгдсэн байдлаар сумдад чиглэл мэдээлэл өгөх шаардлагатай байна./

Аймгийн ОНХС - Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд унтуулгын аппарат авах 79.99 сая төгрөгийн ажил байнгын хэрэгцээтэй, нэн шаардлагатай эрүүл мэндийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

Хархорин сум - Цэцэрлэгийн хүүхдийн тоглоом нэмэгдүүлэх 147.6 сая төгрөгийн ажлаар сумын 5 цэцэрлэгт хүртээмжтэй байдлаар гадна тоглоомын талбайн тохижилт хийж STEM /AR интерактив/ тоглоомоор хангасан. Энэ жишиг хөтөлбөр болон цэцэрлэгүүдэд туршлага солилцон, илтгэл тавьсан. 925 хүүхдэд үр өгөөжтэй ажил болсон байна.

Бат-Өлзий сум - Жогом хороолол руу тог татах 80.5 сая төгрөгийн ажил 700 иргэнд үр өгөөжтэй ажил болсон бөгөөд тогны хүч муу болон тог цахилгаан хүрэлцээгүй айл өрхүүдийг тог цахилгаанаар хангасан байна.

Хужирт сум - Смарт худгийн тоног төхөөрөмж 22.0 сая төгрөгийн ажил хийгдэн иргэд 24 цагаар ундны усаар хангагдах боломж бүрдэж, иргэд сэтгэл хангалуун байна. Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж буюу дизель генератор 6653 иргэд эрүүл мэндийн үйлчилгээг тасалдалгүй хүргэх боломжтой болсон.

Богд сум - Бага сургуулийг зөөж хөл бөмбөгийн талбай байгуулах 66.7 сая төгрөгийн ажил-Сагс, хөл бөмбөгийн талбай нь хүүхэд залуучуудын чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэх их ач холбогдолтой болсон.

Нийтийн халуун ус барих 190.9 сая төгрөгийн ажил- Өвөрхангай аймгийн хамгийн алслагдсан суманд иргэд олон төрлийн үйлчилгээг /саун, дүш, хувцас угаалга, гоо сайхан/ нэг дороос авах таатай нөхцөл бүрдсэн бөгөөд сард дунджаар 500-600 орчим хүн үйлчлүүлдэг.

Хайрхандулаан сум - Соёлын төвийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх 59.8 сая төгрөгийн ажил иж бүрэн тоног төхөөрөмжөөр ханган, нийтийн номын сангийн тохижилт хийж соёлын үйл ажиллагааг ард иргэдэд хүргэх орчин нөхцөл сайжирсан.

Төгрөг сум - Хүүхдийн цэцэрлэгийн дотор засвар, гал тогооны засварын 19.0 сая төгрөгийн ажил тус цэцэрлэгт суралцаж буй 124 хүүхдийн сургалтын таатай орчныг бүрдүүлсэн ажил болсон. Тухайн барилга нь өндөр насжилттай барилга боловч тус цэцэрлэгийн хувьд тогтмол засвар арчлалтыг сайн хийж тохитой орчин бүрджээ.

Баянгол сум - Ахмадын өргөөний засвар, тохижилтын ажил 34.9 сая төгрөгийн ажил ашиглалтгүй 2 өрөөг тоглолтын хувцас солих өрөө, гал тогооны өрөө болгон хаалга хийж засварласан. Нэгдсэн байдлаар халаалтыг шинэчлэн ахмадуудад тав тухтай орчныг бүрдүүлсэн. Өдөрт 60-100 ахмадууд ахмадын өргөөгөөр ирж чөлөөт цагаа өнгөрүүлдэг.

Гучин-Ус сум - Сумын төвийн гэрэлтүүлэг 29.95 сая төгрөгийн ажил гэрэлтүүлэг үүд нь нараар цэнэгээ хураадаг байдлаар шийдсэн нь ашиглалтын зардал хэмнэсэн ажил болсон.

Ногоон байгууламж нэмэгдүүлэх 40.0 сая төгрөгийн ажил говийн бүсийн суманд голын эргийн дагуу бургас тариалан ойн зурвасыг бий болгож байгаа сайн туршлага болсон.

Арвайхээр сум - Хог тээврийн машин, нийтийн тээврийн автобус худалдан авах 174.0 сая төгрөгийн ажил, орон сууцны гадна хогийн сав нэмэгдүүлэх 33.1 сая төгрөгийн ажлууд хийгдсэнээр орчны хог хаягдал багсан сумын хүн амын 70.0 хувь орчим буюу 26.6 мянга хүн өгөөж хүртсэн.

Нарийнтээл сум - Сумын төвийн иргэний танхимын тохижилт 21.15 сая төгрөгийн ажлаар иргэдэд үйлчилдэг танхимыг тохижуулан, тоног төхөөрөмжөөр хангаж иргэдэд үйлчилгээ хүргэх таатай нөхцөл бүрдсэн.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хийгдсэн нийт 326 ТАХ-ээс 172 ажил буюу 52.6 хувь шууд худалдан авалтаар хийгдэж буй 20.0 сая төгрөгөөс доош төгрөгийн ажил байна. Хэт жижиг олон төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь урт хугацаандаа орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахуйц боломжийг хааж байгаа бөгөөд энэ асуудал жил бүр давтагдан гарсаар байна. Журамд ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ гэж заасан байдаг. Иймд сумдын хувьд сангийн гол зорилгыг анхааран төлөвлөлтөд илүү сайн ач холбогдол өгөх шаардлагатай юм.


2.3. Зарим сумдад ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг бүрэн хүчин чадлаар ашиглахгүй, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байгаа тул аймаг, сумдын ИТХ-с Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хяналтыг тогтмол хийж хэвших шаардлагатай байна.

2.3.1. Зарим ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгүүдийг бүрэн хүчин чадлаар ашиглахгүй байгаа бөгөөд камер ашиглалт дээр сумдад сайн анхаарах шаардлагатай байна.

Аудитаар 326 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авалт, ашиглалтыг шалгасан ба ихэнх нь зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглагдаж байна. Харин дараах 7 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар ашиглаагүй, цаашид ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

- Уянга сумын 2023 оны Хадлангийн зориулалттай иж бүрэн техник, тоног төхөөрөмж худалдан авах / төсөв 60,620 сая.төг/ ажлын трактор дагалдах тоног, төхөөрөмжөө дийлдэггүй. Тухайн тоног, төхөөрөмжүүдийг хүлээн авснаас хойш зөвхөн нэг иргэнд сарын 100,000.00 төгрөгөөр түрээсэлж байна.

Зураг 9. Уянга сумын хадлангийн зориулалттай их бүрэн трактор



- Баянгол сумын Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургуулийн спорт заалны хяналтын камер шинэчлэх ажлыг 33.00 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил- Хяналтын камерийг суурилуулахдаа хүүхдийн гар хүрэх өндөрт суулгаж улмаар хүүхдүүд тухайн камерийн чиглэлийг өөрчилдөг байдлаас үүдэж хяналтын камер ашиглалт бүрэн бус байдал бий болдог, спорт заалны камерийг бөмбөгний хамгаалалтгүй суулгаснаас камерыг бөмбөгөөр онож эвдэх, хүүхдийн хувцас солих өрөөнд суурьлуулж хүүхдийн эрх зөрчих зэрэг эрсдэлтэй байна.

Зураг 10. Баянгол сумын ЕБС, СӨББ-н хяналтын камер



- Баянгол сумын ЭМТ-н шүдний кабинет тохижуулах 19.8 сая төгрөгийн ажил шүдний эмч байхгүй тул ашиглалтгүй байна.
- Төгрөг сумын төвийн камер, гэрэлтүүлгийн 83.9 сая төгрөгийн төсөвтэй ажил хийгдсэн нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 30ш камер ажиллах ёстойгоос 4ш камер ажиллаж байна. Ажиллахгүй байгаа камеруудын шалтгааныг тодруулж байнгын ажиллагаатай болгох ажил хийдэггүй.

Зураг 11. Төгрөг сумын хяналтын камер



- Төгрөг сумын Цэцэрлэгт хүрээлэн нийтийн эзэмшлийн хайс болон зам талбайн тохижилт хийх ажлын дагуу худалдан авсан 4.55 сая төгрөгийн үнэтэй өвс пресслэгч ашиглалтгүй. Учир нь худалдан авч буй өвс, тэжээл нь бүгд пресслэсэн, сав, баглаа боодолтойгоо ирдэг.
- Богд сумын төвийн чиглэлийн камержуулалтын ажлаар хийгдсэн нийт 52 ширхэг камеруудаас нийтийн эзэмшлийн газрын чиглэлийн-6, PTZ-1 камер ажиллахгүй байна. Захиалагч тал камер ажиллахгүй байгаа шалтгааныг тодруулж, хэрэв нийлүүлэгчээс хамаарах асуудал байгаа бол шуурхай шийдвэрлүүлэх шаардлагатай.
- Хархорин сумын Хадлангийн талбай хаших хашааг 62.34 сая төгрөгөөр худалдан авсан боловч хадлангийн талбай хашаагүй, хураалттай, ашиглалтгүй байна.

Зураг 12. Хархорин сумын хадлангийн талбай хашиг хашаа



2.3.2. Зарим сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалт муугаас, эвдэрч хэмхэрсэн байдалтай байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-ний хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.¹⁰ Үүнд:

- Бат-Өлзий сумын наадмын талбайн засварын ажлаар хийгдсэн наадмын талбайн дэргэдэх 7ш ЭКО нойлын хадгалалт муу, 1 нойл дээвэргүй, 2 нойл хаалгагүй болсон. Сумын иргэд эвдэж байна.

Зураг 13. Бат-Өлзий сумын ЭКО нойл



- Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хатуу эдлэл эвдрэл ихтэй, төмөр орны холболт салсан, шүүгээний доод тавцан салсан гэх мэт.

Зураг 14. Бат-Өлзий сумын ЕБС хатуу эдлэл



- Тарагтын сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гаднах хүүдийн тоглоомын талбайн бэхэлгээ чанаргүй. Хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал сайжруулах шаардлагатай байна.


Зураг 15. Тарагт сумын СӨББ-н гаднах хүүхдийн тоглоом



- Хужирт сумын Соёлын төвийн урлагийн хувцас, техник шинэчлэх ажлаар хийгдсэн LED дэлгэц дээврээс дусаал гоожсоноос шалтгаалан нэг нүд дэлгэц шатсан байна. **Хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт сайн жишээнээс дурдахад:**
- Нарийнтээл сумын спорт заал, ерөнхий боловсролын сургуулийг камержуулах ажилаар хийгдсэн спорт заалны камерийг сургуулийн зүгээс гадуур төмөр тор /гал тогооны хөлдөөгчид ирсэн төмөр сагс/ хийж механик эвдрэлээс хамгаалсан.

¹⁰ Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.12-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга, байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

Зураг 16. Нарийнтуул сумын ЕБС-н хяналтын камер



- Сумдын цэцэрлэгүүдийн хувьд гадна байрлах Хүүхдийн тоглоомыг ашиглахгүй үед сайн хамгаалдаг /гадна тоглоомуудыг хучиж, боох, боломжтой бол түр салган дотор агуулахад хадгалах гэх мэт/

Аудитаар ажиглагдсан асуудал - Нийтийн эзэмшлийн талбайд байрлах эд хөрөнгийг иргэдийн зүгээс зүй бусаар ашиглах, эвдэх, хулгайлах зэрэг зөрчил гарч байгааг анхааралтай авч үзэх шаардлагатай байна. Иймд уг эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын үр нөлөөг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, иргэдийн хандлага, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах нь зүйтэй. Тухайлбал, олон нийтийн оролцоог дэмжсэн уриалгууд, мэдээлэл түгээх ажил, ухамсар төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа зэргийг хариуцсан албан тушаалтны зүгээс үе шаттайгаар зохион байгуулж, тогтмол үр дүнг хянаж байхаар санал болгож байна.

Хөрөнгийн хадгалалт хамгаалалтийг эзэмшигч байгууллага хариуцахаас гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1-д Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал “орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах,” бүрэн эрхтэй гэж заасан. Иймд аймаг, сумдын ИТХ-аас хөрөнгийн хадгалалт, хамгаалалттай холбоотой хяналтыг тогтмол хийж хэвших шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛЖ, ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, МЭДЭЭГ ҮНЭН ЗӨВ ИЛЭРХИЙЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавьсан хяналт хангалтгүй байна.

3.1.1 Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ түүний үр дүнд тавих хяналтыг тогтмол хийж хэвшээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” -н 9.4-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина гэж заасан байна.

Тус журамд зааснаар аймаг сумын ИТХ болон аймгийн засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж байна. Журмын 4.3-д “Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нь өөрийн хариуцах асуудлын хамрах хүрээнээс шалтгаалан дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх дотоод аудитор

ажиллуулж болно” гэж заасан ч сумдын Засаг дарга ОНХС-ийнн хөрөнгийн зарцуулалтад дотоод аудитыг огт хэрэгжүүлэхгүй байна.

Хүснэгт 11. Аймаг, сумдын ИТХ-аас 2024 онд ОНХС-ийн ТАХ-нд хяналт хийсэн тоо

№	Сумын нэр	2024 хэрэгжүүлсэн ТАХ-ний тоо	ИТХ-с хяналт хийсэн ТАХ-ний тоо	Хувь
1	Бүрд	9	0	0
2	Хархорин	13	0	0
3	Аймаг	24	1	4
4	Нарийнтээл	24	2	8
5	Сант	13	1	8
6	Уянга	23	2	9
7	Арвайхээр	18	3	17
8	Богд	16	3	19
9	Хайрхандулаан	16	3	19
10	Есөнзүйл	14	3	21
11	Баянгол	21	8	38
12	Зүүнбаян-Улаан	8	3	38
13	Өлзийт	10	4	40
14	Тарагт	10	4	40
15	Төгрөг	17	7	41
16	Гучин-Ус	20	9	45
17	Баян-Өндөр	21	11	52
18	Хужирт	16	9	56
19	Баруунбаян-Улаан	12	7	58
20	Бат-Өлзий	19	12	63
Нийт		324	92	Дундаж: 28

Дээрх хүснэгтээс Бат-Өлзий, Баруунбаян-Улаан, Хужирт, Баян-Өндөр сумын ИТХ ОНХС-н хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хяналтыг 50%-с их, бусад сумдын хяналт 50%-с бага байна. Үүнээс Бүрд, Хархорин, Нарийнтээл, Сант, Уянга сум болон Аймгийн ИТХ 10.0 хувиас бага байна. Аймгийн хэмжээнд ИТХ-н хяналт дунджаар 28.0 хувьтай буюу хангалтгүй байна.

Аймаг, сумын ИТХ-аас ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд тавих хяналтын төлөвлөгөөг тогтмол гаргаж байгаа ч хяналтын бүрэлдэхүүнд орсон төлөөлөгч /төлөөлөгч нар ажил ихтэй гэх шалтгаанаар/ нараас шалтгаалж төлөвлөсөн бүх ажилдаа бүрэн хяналт тавихгүй байна.


Аймгийн засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь 2025 онд 4 сумын 2024 оны ОНХС-н зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд хяналт тавихаар төлөвлөсөн ба эхний хагас жилийн байдлаар Бат-Өлзий /14.3 сая төгрөгийн авлагыг илүү тусгасан зөрчил илрүүлж, 6 заалт бүхий зөвлөмж өгсөн/, Сант /23.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 9 заалт бүхий зөвлөмж/, Хужирт /4.4 төгрөгийн зөрчил илрүүлж, 6 заалт бүхий зөвлөмж өгсөн/ сумдад төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийсэн байна.

Аймаг болон сумдын ИТХ-ын хяналт сайжран; Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас илүү олон сумыг хяналт шалгалтад хамруулан; сумдын засаг дарга нар ОНХС-н хөрөнгийн зарцуулалтад дотоод аудитыг тодорхой хэмжээнд хийж гүйцэтгэвэл ОНХС-н үйл ажиллагаа сайжран, зөрчил буурах бүрэн боломжтой юм. Иймд энэхүү асуудалд аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарын зүгээс онцгойлон анхаарах шаардлагатай юм.

3.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлд хийсэн захиалагчийн хяналтын хэрэгжилт хангалтгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.3, 3.3.5, 3.4.3-т аймаг, сумын Засаг дарга ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт тавьж цаашид авах арга хэмжээг зохион байгуулахаар заасан.

Дүрслэл 12. ИТХ-аас хяналт хэрэгжүүлсэн байдал



Аймаг, сумын хэмжээнд 2024 онд 14,386.9 сая төгрөгийн 326 ТАХ хэрэгжсэнээс 9,475.2 сая төгрөгийн 169 ТАХ-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, 4,911.7 сая төгрөгийн 157 ТАХ-нд буюу 48.2 хувьд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 12. Захиалагчийн хяналт

№	Аймаг, сумын нэр	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээ		Захиалагчийн хяналт				Хэрэгжилтийн хувь
				Хэрэгжүүлсэн ТAХ		Хэрэгжүүлээгүй ТAХ		
		тоо	2024 олгосон санхүүжилтийн дүн	тоо	2024 олгосон санхүүжилтийн дүн	тоо	2024 олгосон санхүүжилтийн дүн	
1	Арвайхээр	18	1,094.1	18	1,094.1	0	-	100.0%
2	Баруунбаян-Улаан	12	360.1	12	360.1	0	-	100.0%
3	Бат-Өлзий	19	716.6	7	294.6	12	422.0	36.8%
4	Баянгол	21	475.5	11	137.0	10	338.5	52.4%
5	Баян-Өндөр	21	421.7	19	387.5	2	34.2	90.5%
6	Богд	16	1,011.4	12	835.8	4	175.6	75.0%
7	Бүрд	9	764.3	1	585.2	8	179.1	11.1%
8	Гучин-Ус	20	622.3		-	20	622.3	0.0%
9	Есөнзүйл	14	192.6	14	192.6	0	-	100.0%
10	Зүүнбаян-Улаан	8	237.0	2	159.8	6	77.2	25.0%
11	Нарийнтээл	24	681.7	9	437.3	15	244.5	37.5%
12	Өлзийт	10	110.2	7	101.8	3	8.4	70.0%
13	Сант	13	445.2	13	445.2	0	-	100.0%
14	Тарагт	12	293.6	4	96.9	8	196.7	33.3%
15	Төгрөг	17	674.3		-	17	674.3	0.0%
16	Уянга	23	512.0			23	512.0	0.0%
17	Хайрхандулаан	16	478.1	16	478.1	0	-	100.0%
18	Хархорин	13	634.0	3	237.7	10	396.3	23.1%
19	Хужирт	16	431.3		-	16	431.3	0.0%
20	Аймгийн ОНХС	24	4,230.7	21	3,631.4	3	599.3	87.5%
	Нийт дүн	326	14,386.9	169	9,475.2	157	4,911.7	

Хүснэгтээс харахад аймаг, Арвайхээр, Баруунбаян-Улаан, Баян-Өндөр, Есөнзүйл, Сант, Хайрхандулаан, Богд, Өлзийт сумд захиалагчийн хяналтыг сайн хэрэгжүүлсэн бол дараах сумд хяналтын хангалттай хэрэгжүүлээгүй, зарим сумд огт хяналт тавиагүй байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Бат-Өлзий сум 36.8 хувь, Баянгол сум 52.4 хувь, Бүрд сум сум 11.1 хувь, Зүүнбаян-Улаан сум 25.0 хувь, Нарийнтээл сум 37.5 хувь, Тарагт сум 33.3 хувь, Хархорин сум 23.1 хувьтай чанарын хяналтыг хэрэгжүүлсэн байна.
- Гучин-Ус сум 622.3 сая төгрөгийн 20, Төгрөг сум 674.3 сая төгрөгийн 17, Уянга сум 512.0 сая төгрөгийн 23, Хужирт сум 431.3 сая төгрөгийн 16 ТАХ-нд хяналтыг огт хийгээгүй байна.

Захиалагчийн зүгээс төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт бүрэн тавихгүй байгаагаас үүдэн дараах зөрчлүүд тогтмол гарсаар байна. Үүнд:

- Төсөл, арга хэмжээний чанар стандартын шаардлага хангахгүй байх;
- Зураг төсөв, тоо хэмжээг захиалагч болон гүйцэтгэгч дур мэдэн өөрчлөх;
- ТАХ нь гэрээний хугацаандаа хэрэгжихгүй байх;
- Үр дүнгүй, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй ТАХ хэрэгжих;
- Барилга, байгууламжийг хувьд баригдаж дууссан хойно засварлах боломжгүй алдаа, зөрчлүүд илэрдэг боловч эдгээрийг арилгах нөхцөлгүй болсон тул ямар нэгэн байдлаар хүлээн авч, ашиглалтад оруулах шийдвэрийг гаргахад хүрч байна. ТАХ-г хүлээж авах ажлын комиссын зүгээс ажлын биелэлт, гүйцэтгэлийн чанар, тоо хэмжээ зэрэгт нарийн хяналт тавьдаггүй, мөн тухайн төслийн талаар анхны ойлголт дутмаг байдаг тул гүйцэтгэгчийн өгч буй тайлбар, мэдээлэлд үндэслэн тухайн ажлыг асуудалгүй хэмээн үзэж, хүлээн авдаг нөхцөл бүрдэж байна. Мөн захиалагчийн зүгээс баталсан зураг төсөл, төсөв нь анхнаасаа алдаа, дутагдалтай байх тохиолдол байна. Үүнийг гүйцэтгэгч байгууллага “танай зураг төсөв ийм байсан” гэх үндэслэлээр тайлбарлаж, тухайн ажил дутуу байсан ч захиалагч тал хүлээн авах нөхцөлд хүрч байна.

Мөн хяналт тавих ажлын хэсэгт мэргэжлийн бус хүмүүсийг томилж ажиллуулснаар:

- Чанарын шаардлага хангахгүй ажил хүлээн авах;
- Ажлын гүйцэтгэлийг бодитоор үнэлэх боломжгүй болох

Сумдад захиалагчийн хяналтыг хийж гүйцэтгэхдээ тухайн ТАХ-ний сайжруулах шаардлагатай, ажлын тоо хэмжээнээс зөрүүтэй зөрчлүүдийг засах хугацаатай үүрэг даалгаврыг албажуулсан байдлаар өгөхгүй /амаар хэлсэн гэх/, хяналтын ажлын хэсэг тус ТАХ-тэй холбоотой нарийн мэдлэг мэдээлэл дутмаг байгаа нийтлэг асуудал байна.

Үүнээс шалтгаалан ТАХ хэрэгжилтийн хугацаа хэтрэх, ажлын чанар муудах, үр ашиггүй болох эрсдэл ихээр ажиглагдаж байна. Иймд сумдад дотоод зохион байгуулалтыг сайжруулан тухайн ТАХ-ний онцлогт тааруулан боломжит мэргэжлийн хүмүүсийг оролцуулан хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг томилох нь зүйтэй юм.

Шийдвэрлэлт: ОНХС-ийн хэрэгжилтэд хууль тогтоомжийн дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй болон хангалтгүй хэрэгжүүлсэн 11 сумын Засаг дарга нарт зөрчил арилгах цаашид хяналтыг тогтмол хэрэгжүүлэх Зөвлөмж хүргүүлэв.

3.1.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт өмнөх гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлсэн боловч алдаа зөрчлүүд давтан гарсан, биелэлт хангалтгүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт аудитаар 2024 онд нийт 4,434.1 төгрөгийн 8 зөвлөмж, 5,865.3 төгрөгийн 15 албан шаардлага холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн бөгөөд 95.6 хувийн биелэлттэй гэж ирүүлсэн боловч талбар дээр очин хэрэгжилтийг дахин шалган үзэхэд бодит байдал дээр 78.1 хувийн биелэлттэй байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн дараах зөрчлүүд биелэгдээгүй байна.

1. Гучин-Ус сумын гэр хорооллыг дулааны шугам сүлжээнд холбох 296.2 сая төгрөгийн ажил ашиглалтгүй хэвээр байна.
2. Хужирт сумын Төрийн албан хаагчийн орон сууц шинээр баригдаж байгаа 674.0 сая төгрөгийн ажил дуусаагүй, зогсонги байдалтай хэвээр байна. Мөн тус барилгын гүйцэтгэгч болох Отгонинж ХХК 2021 онд барьсан “Хужиртад үйлдвэрлэв” төв одоог хүртэл ашиглалтгүй, эвдрэл, цууралт өгч эхэлсэн байна.
3. Хужирт сумын 2-р цэцэрлэгийн хүнсний агуулах барих ажил 19.6 сая төгрөгөөр хийгдсэн боловч чанар муу болсон, дахин засварлаагүй ашиглалтад ороогүй байна.
4. ОНХС-ийн санхүүжилтээр 2023 онд бий болсон 5 төрлийн 447.5 сая төгрөгийн хөрөнгийг буруу тайлагнасныг анхан шатны баримт үндэслэн хөрөнгө тус бүрээр

салгаж, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийж бүртгэлд тусгуулсан боловч 1,063.5 сая төгрөгийн зөрчил дахин гарсан байна.

5. Иргэдийн саналд тусгаадаагүй 27 төрлийн 3,741.3 сая төгрөгийн ажлыг аймгийн ОНХС-аас 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан бол 2024 онд иргэдийн саналд тусгаадаагүй 639.3 сая төгрөгийн 4 ажлыг төлөвлөж баталсан нь өмнөх оноос буурсан үзүүлэлт боловч өмнөх оны зөрчил бүрэн арилаагүй байна.
6. Уянга суманд 179.5 сая төгрөгөөр мал нядалгааны цехийн зарим ажлууд дуусаагүй, ашиглалтгүй байна
7. Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийн мэдээллийг УМС-д үнэн зөв, бүрэн оруулаагүй.
8. Тарагт сумын Ногоон байгууламжийн хайсан хашаа барих ажил 20.0 сая төгрөг, гэрэлтүүлгийн ажил 6.0 сая төгрөгийн 2 ТАХ шүүхийн байгууллагат шилжсэн байна.

Зураг 17. Хужирт сумын төрийн албан хаагчийн барилга



Зураг 18. Хужирт сумын 2-р Цэцэрлэгийн хүнсний агуулах



Зураг 19. Хужирт сумын "Хужиртад үйлдвэрлэв төв"-н барилга



Шийдвэрлэлт: Дээрх зөрчлүүдийг арилгаагүй болон дахин гаргасан холбогдох албан тушаалтнуудад зөрчлийг таслан зогсоох, дахин гаргахгүй байх талаар албан шаардлага, мөн хариуцлага тооцох тухай шаардлагыг хүргүүлэв. Сонгуулийн үр дүнгээр зарим сумдын холбогдох албан тушаалтнууд ажлаас чөлөөлөгдсөн тул хариуцлага тооцох боломжгүй байсан тул албан шаардлага хүргүүлэв.



3.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн тайлангийн мэдээллийн үнэн зөв байдал дутмаг, хөрөнгийг буруу дүнгээр бүртгэх, бүртгэлд огт тусгахгүй байгаа зөрчил давтан гарсаар байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн боловч мэдээллийн үнэн зөв байдал дутмаг байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3, 9.9, 9.11-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайлан гаргах, хүргэх зохицуулалтыг тусгасан байна.¹¹ Гэвч аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэрэгжилтийн тайланг аймаг, сумдаар гаргаж журамд заасны дагуу тайлагнасан боловч мэдээлэл дутуу, зөрүүтэй /ажлын гүйцэтгэлийн хувь бодит байдлаас зөрүүтэй, зарим ТАХ -ын гүйцэтгэлийн хувь оруулаагүй г.м/ байна.

Тус хэрэгжилтийн тайланг үнэн зөв гарган, дүн шинжилгээг хийснээр ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулахад өндөр ач холбогдолтой юм. Иймд журмын дагуу сумын Засаг даргын тамгын газрын дарга нар болон БОНХОБТХ нь мэдээллийн үнэн зөв байдалд анхаарч, хоорондын уялдаат байдлыг бүрэн хангаж ажиллах нь зүйтэй.

Мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах үүднээс тайлант оны эцэст багийн иргэдийн нийтийн хурал дээр багийн засаг дарга нар тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын тайлангаа танилцуулж хэвшсэн байна. Мөн зарим сумын засаг даргын тамгын газрын цахим болон фэйсбүүк хуудсаар дамжуулж тухайн тайлангуудыг нээлттэй байршуулж иргэдэд тухай бүр тогтмол мэдээллэдэг сайн жишиг тогтсон байна. Дараах QR кодыг уншуулж сум тус бүрийн мэдээг унших боломжтой.



3.2.2. ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон 1,011.5 сая төгрөгийн хөрөнгийг буруу дүнгээр бүртгэж, 52.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд огт тусгаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэж заасан.

Аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн ТАХ-ний 77.2 хувь буюу 8,148.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 7.4 хувь буюу 775.6 сая төгрөгийн бараа материалыг ашиглагч байгууллагууд орлого авч данс бүртгэлд тусгасан, 15.4 хувь 1,627.3 сая төгрөгийн зарцуулалтыг урсгал зардлаар тайлагнасан байна.

¹¹ ¹¹ Журмын 9.2 дахь заалт: Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

¹¹ Журмын 9.9 дэх заалт: Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана...

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тарагт сум 233.76 сая төгрөгийн 2 ТАХ, Уянга сум 20.0 сая төгрөгийн 1 ТАХ, Зүүнбаян-Улаан сум 10.0 сая төгрөгийн 1 ТАХ, Бат-Өлзий сум 198.35 сая төгрөгийн 3 ТАХ, Хужирт сум 41.90 сая төгрөгийн 1 ТАХ, Хархорин сум 41.76 сая төгрөгийн 2 ТАХ, Баянгол сум 51.96 сая төгрөгийн 2 ТАХ, Гучин-Ус сум 115.02 сая төгрөгийн 3 ТАХ, Төгрөг сум 210.88 сая төгрөгийн 2 ТАХ, Богд сум 93.76 сая төгрөгийн 3 ТАХ, Хайрхандулаан сум 46.10 сая төгрөгийн 1 ТАХ-г тус тус НББ-д үнэн зөв тусгаагүй байна. /хавсралт 3- дэлгэрэнгүй/

Хөрөнгийн бүртгэлийг буруу хийх /бүхэл дүнгээр бүртгэх/, орлогот бүртгэхгүй байх нь тухайн хөрөнгө эзэнгүйдэх, бүхэл дүнгээр бүртгэгдсэн хөрөнгүүдийн хадгалалт хамгаалалтыг бүрэн хийх боломжгүй байх, хөрөнгийн үнэлгээ буруу тогтоогдох, шамшигдах зэрэг эрсдэлийг дагуулж байна.


Шийдвэрлэлт: НББ тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус зөрчсөн холбогдох албан тушаалтнуудад зөрчлийг таслан зогсоох, дахин гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэв.

3.2.3. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэдэд нээлттэй мэдээлсэн боловч аймаг болон 8 сум мэдээллийг УМС-д дутуу оруулсан, огт оруулаагүй байгаа зөрчил гарсаар байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 10 дугаар бүлэгт ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг Удирдлагын мэдээллийн системд бүртгэх талаар тусгаж, иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх үүргийг заасан. Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, хяналт, бүртгэлийг удирдлагын мэдээллийн системд оруулах чиг үүрэгтэй.

Баян-Өндөр, Бүрд, Гучин-Ус, Өлзийт, Төгрөг, Хайрхандулаан сумд Удирдлагын мэдээллийн системд бүрэн гүйцэт журмын дагуу мэдээллийг оруулсан байна.

Дүрслэл 13. УМС-д дутуу оруулсан, огт оруулаагүй ТАХ-ний тоо



Харин аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 27 төрлийн 8,453,782 сая төгрөгийн ТАХ-ээс, 23 төрлийн ТАХ-ний мэдээллийг дутуу оруулсан, 1 төрлийн 19,800 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй, сумдууд 9 төрлийн 231,236 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг дутуу оруулсан, 40 төрлийн 1,046,840 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын ¹² 10.2.ОНХС-ийн хуваарилалт,

¹² 10.2.1.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;

10.2.2.ОНХС-аас аймаг, нийслэлд шилжүүлэх орлогын шилжүүлгийн сар, улирлын батлагдсан хуваарийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС хариуцсан нэгж жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;

төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна. Мэдээллийг үнэн зөв бүрэн оруулаагүйгээс иргэд мэдээлэл авах боломж бүрдэхгүй байна. /Хавсралт 2-р дэлгэрэнгүй/

Дүрслэл 14. Иргэдээс авсан санал асуулга



7. Орон нутгийн хөгжлийн сангийн "Удирдлагын мэдээллийн системээс ямар төрлийн мэдээлэл авдаг вэ? гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 179 буюу 11,8 хувь нь сангийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой, 218 буюу 14,4 хувь нь худалдан авах ажиллагаатай холбоотой, 224 буюу 14,8 хувь нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, биелэлттэй холбоотой, 892 буюу 59,0 хувь нь мэдээлэл авдаггүй гэж хариулсан байна.

ОНХС-ийн www.onhs.mof.gov.mn удирдлагын мэдээллийн системээс аймаг болон сумын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн талаарх мэдээллийг авах боломжтой хэдий ч санал асуулгаар иргэд мэдээлэл дутмаг байгаа нь харагдаж байна. Иймээс иргэдийг мэдээллээр ханган, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Удирдлагын мэдээллийн системд урд оноос дамжин хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг оруулахад иргэдийн санал аваагүй гэсэн төлөвтэй алдаатай харагддаг талаар сумдууд санал хэлж байлаа. Иймд системийн алдаатай байдалд мөн анхаарах шаардлагатай байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 27 төрлийн 8,453.8 сая төгрөгийн ТАХ-ээс, 23 төрлийн ТАХ-ний мэдээллийг дутуу оруулсан, 1 төрлийн 19.8 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй.
2. Арвайхээр сум 1 төрлийн 45.0 сая төгрөгийн ТАХ дутуу оруулсан, Баруунбаян-Улаан сум 3 төрлийн 102.9 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй, Бат-Өлзий сум 1 төрлийн 69.0 сая төгрөгийн ТАХ дутуу оруулсан, Баянгол сум 6 төрлийн 135.5 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй, Богд сум 4 төрлийн 157.8 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй, Есөнзүйл сум 3 төрлийн 53.0 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг дутуу оруулсан, Зүүнбаян-Улаан сум 2 төрлийн 19.8 сая төгрөгийн мэдээллийг огт оруулаагүй, Нарийнтээл сум 3 төрлийн 37.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ дутуу оруулсан, 11 төрлийн 198.2 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй, Сант сум 2 төрлийн 130.3 сая төгрөгийн мэдээллийг огт оруулаагүй, Тарагт сум 1 төрлийн 27.2 сая төгрөгийн ТАХ дутуу оруулсан, Уянга сум 8 төрлийн 156.9 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй, Хархорин сум 1 төрлийн 17.4 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй, Хужирт сум 3 төрлийн 128.0 сая төгрөгийн ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй байна.

10.2.3.Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь орон нутгийн төсвийн батлагдсан сар, улирлын хуваарьтай нийцүүлэн ОНХС-ийн сум, дүүргээр хуваарилан баталсан сар, улирлын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;

10.2.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС хариуцсан нэгж нь ОНХС-ийн орлогын шилжүүлгийг Төв төрийн сангийн сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ гарсны дараа ажлын 5 хоногийн дотор аймаг, нийслэлийн ОНХС-ийн дансанд шилжүүлж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ;

10.2.5.Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хуваарилагдан ирсэн орлогын шилжүүлгийг ажлын 2 өдөрт багтаан батлагдсан хуваарийн дагуу сум, дүүргэтээ хуваарилж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ.

3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны жилийн эцсийн СТА-аар “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд аудитаар сум, аймгийн нийт 9 ОНХС-ийн 9,757.3 сая төгрөгийн 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, хөрөнгө мөнгө зарцуулах тухай тушаал шийдвэрийн мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчилд 1 зөвлөмж, 8 албан шаардлага өгч, биелэлтийг тооцож ажилласан.

Хүснэгт 13. Шилэн дансны зөрчлийг өмнөх онтой харьцуулсан байдал

Үзүүлэлт	2023 он	2024 он	Харьцуулалт
Нийт байгууллагын тоо	7 байгууллага	9 байгууллага	+2 нэмэгдсэн
Зөрчлийн нийт дүн	4,980.7 сая ₮	9,757.3 сая ₮	+4,776.6 сая ₮
Албан шаардлагын тоо	7	8	+1 нэмэгдсэн
Албан шаардлагын дүн	4,980.7 сая ₮	9,632.4 сая ₮	+4,651.7 сая ₮
Зөвлөмж гаргасан	0	1	+1 нэмэгдсэн
Зөвлөмжийн дүн	0	124.9 сая ₮	+124.9 сая ₮

Хүснэгтээс харахад Шилэн дансны тухай хуулийн зөрчил нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь байгууллагын холбогдох албан хаагчид иргэд олон нийтэд ил тод, үнэн зөв мэдээлэл хүргэхэд анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

Шилэн дансны зөрчлийг байгууллагаар харуулбал:

Хүснэгт 14. Шилэн дансны зөрчлийг байгууллагаар харьцуулсан байдал

№	Байгууллага	2023 оны зөрчлийн дүн				2024 оны зөрчлийн дүн			
		Зөвлөмж		Албан шаардлага		Зөвлөмж		Албан шаардлага	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Бат-Өлзий сум	-	-	1	1,426.6	-	-	-	-
2	Нарийнтээл сум	-	-	1	657.3	-	-	-	-
3	Баянгол сум	-	-	1	102.4	-	-	-	-
4	Хужирт сум	-	-	1	1,100.9	-	-	-	-
5	Бүрд сум	-	-	1	631.5	-	-	-	-
6	Төгрөг сум	-	-	1	334.4	-	-	-	-
7	Сант сум	-	-	1	727.6	-	-	-	-
8	Арвайхээр сум	-	-	-	-	-	-	1	1,067.4
9	Уянга сум	-	-	-	-	-	-	1	414.4
10	Хайрхандулаан сум	-	-	-	-	1	124.9	-	-
11	Баян-Өндөр сум	-	-	-	-	-	-	1	572.8
12	Зүүнбаян-Улаан сум	-	-	-	-	-	-	1	133.8
13	Богд сум	-	-	-	-	-	-	1	1,586.5
14	Тарагт сум	-	-	-	-	-	-	1	660.4
15	Хархорин сум	-	-	-	-	-	-	1	983.9
16	Аймгийн ОНХС	-	-	-	-	-	-	1	4,213.2
Нийт дүн		-	-	7	4,980.7	1	124.9	8	9,632.4

Дээрх хүснэгтүүдээс харахад 2023 онд зөрчил гаргасан байгууллагууд давтан зөрчил гаргаагүй байна. Харин 2024 онд нийт 9 байгууллагад 9,757.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 4,776.6 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2073,
Цахим шуудан: uvurkhangaigai@ov.gov.mn
Цахим хуудас: www.uvurkhangaigai.mn

2025. 08. 01 № 3/491
танай 2025. 07. 29-ны № 406 -Т

Санал хүргүүлэх тухай

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө” сэдэвт аудитын тайлантай танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1.Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 340.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Арвайхээр сумын спортын гудмын авто замын ажил нь шинэ ажил биш тул ажлын зураг шинээр хийх шаардлагагүй гэж үзэн мэргэжлийн төсөвчнөөр засварын ажлын төсөв хийлгэн гүйцэтгүүлсэн.

2.Орон сууцны гадна фасад засварын 4 дүгээр багц ажил Арвайхээр сумын 127 дугаар байрны шугамын засвар, мөн 5 дугаар багц ажил 5, 13, 14 дүгээр байрны шугамын засварын ажлууд нь хэд хэдэн удаа тендер зарлуулсан боловч гүйцэтгэгч сонгон шалгаруулалтад оролцоогүй тул хүйтний улирал эхлэхтэй холбогдуулан шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн.

3.Арвайхээр сумын спортын гудамжны замын ус зайлуулах сувгийг сурын холбосныхон бөглөж сур харвааны бэлтгэлээ хийж байсныг илрүүлэн бөглөөг гаргаж хэвийн байдалд оруулсан бөгөөд дахин ус тогтох асуудал гараагүй.

4.Төв бараан захын авто замын ажлын зурагт “Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл”-өөр хийгдсэн худалдааны павилоныг шилжүүлэн явган хүний замын ажил гүйцэтгэхээр тусгагдсан. Павилоны суурь нь элэгдэлд орж шилжүүлэх боломжгүй байсан тул ажлын тоо хэмжээний зөрүүнд асфальт бетон хучилт, ажлын зурагт тусгаагүй хэсэгт явган хүний зам шинээр хийлгэсэн бөгөөд тоо хэмжээний зөрүүнээс үүссэн төлбөрийг үлдэгдэл санхүүжилтээс хасаж олгох боломжтой.

5.Бат-Өлзий сумын өргөн чөлөөний авто замын ажилд захиалагч, зохиогчийн хяналтыг хийж дахин асфальт бетонон хучилт хийх хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн дагуу улсын комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авснаар үлдэгдэл санхүүжилтийг олгоно.

Иймээс дээрх үндэслэлүүдийг харгалзан үзэж гүйцэтгэлийн аудитын тайланд дээрх ажлуудтай холбоотой дурдагдсан дүгнэлтүүдийг залруулж, хасаж өгөхийг хүсье.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

6225 32 0319

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ХАРИУ

1. Саналыг хүлээн авсан.
2. Орон сууцны гадна фасадын ажлын хувьд аймгийн ХАА-ны 2024 оны төлөвлөгөөнд багцлан зарлахаар төлөвлөн, багцаар зарлаж байх явцдаа шууд гэрээ байгуулсан байсан тул саналыг хүлээн авах боломжгүй юм. Цаашид ХАА-ны төлөвлөөг боловсруулахдаа анхаарч ажиллах зүйтэй.
3. Аудитын явцад ахин тус замын чанар байдлыг үзэхэд ус туналтгүй байсан тул саналыг хүлээн авсан.
4. Тоо хэмжээний зөрүүнд асфальт бетон хучилт, зурагт тусгагдаагүй хэсэгт явган хүний зам шинээр хийлгэсэн талаар баталгаажуулсан тооцоолол аудитын явцад ирүүлээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй. Цаашид зайлшгүй нөхцөл байдлаар зарим ажлын зөрүүг өөр хэсэгт шингээн хийгдсэн ажлуудыг баримтжуулан, баталгаажуулж тооцооллыг ажлын гүйцэтгэлийн баримт бичигт хавсаргаж байх.
5. Аудитын явцад хугацаатай үүрэг даалгаврын талаар мэдээллийг ирүүлээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй. Тус ажлыг яаралтай хийж гүйцэтгүүлэх шаардлагатай юм.



ДҮГНЭЛТ

- Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөн, бүрдүүлж, хуваарилсан боловч МТТАТ-ын он дамжсан авлага буурахгүй, татварын бүрдүүлэлт хангалтгүй байдлаас шалтгаалан зарим ТАХ хэрэгжээгүй байна.
- Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөсөн ч Улсын төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 600.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.
- Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн ч иргэдийн саналгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн зөрчил давтан гаргасаар байна. Мөн нэн тэргүүнд эрэмбэлэгдээгүй зарим ажлыг төлөвлөн, хэрэгжүүлсэн байна.
- Аймаг болон сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-үүдийг үр дүнтэй хэрэгжүүлсэн боловч ихэнх сумдад төсвийг хэт жижиглэн үр нөлөө багатай ажлууд хийх нь түгээмэл байна.
- Аймаг, сумд нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ХАА-нд холбогдох хууль тогтоомжийг бүрэн баримтлаагүй, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгохгүй, чанаргүй ажлуудыг хүлээж авдаг зөрчил давтагдан гарсаар байна. Мөн техникийн тодорхойлолтыг хэт ерөнхий, ойлгомжгүй байдлаар боловсруулсан тохиолдлууд их байна.
- Сумдад төсвийг хэт жижиглэн үр нөлөө багатай олон ажлууд төлөвлөн хэрэгжүүлсээр байгаа ба төсөл хэрэгжүүлснээр шийдвэрлэгдэх асуудлыг хэт ерөнхий байдлаар тусгаснаас шалтгаалан хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрэхгүй байх тохиолдлууд гарч байна.
- Зарим сумдад ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг бүрэн хүчин чадлаар ашиглахгүй, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байгаа тул аймаг, сумдын ИТХ-с Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хяналтыг тогтмол хийж хэвших шаардлагатай байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих захиалагчийн болон ИТХ-ын хяналтыг сайжруулж, чанаржуулан; ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, мэдээг үнэн зөв илэрхийлэн, дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад тавьсан хяналт хангалтгүй байгаа ба хяналтын ажлын хэсгийг томилохдоо холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулах, хяналтаар техникийн тодорхойлолт, батлагдсан зураг, төсвийн дагуу нарийн тулгалтууд хийж, хугацаатай үүрэг даалгавруудыг албажуулан өгч, биелэлтийг хангуулан ажиллах шаардлагатай байна.
- Аймгийн СТСХ, БОНХОБТХ, Засаг даргын дэргэдэх Өмчийн газар, сумдын ажлын уялдаа муугаас хөрөнгийг буруу дүнгээр бүртгэх, бүртгэлд огт тусгахгүй байгаа зөрчил давтан гарч, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн тайлангийн мэдээллийн үнэн зөв байдал алдагдсан байна.
- ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэдэд нээлттэй мэдээлсэн боловч аймаг болон 8 сум мэдээллийг УМС-д дутуу оруулсан, огт оруулаагүй байгаа зөрчил гарсаар байна.
- ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлсэн байна.

САНАЛ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах саналуудыг холбогдох байгууллагуудад хүргүүлж байна. Үүнд:

САНГИЙН ЯАМАНД УЛАМЖЛАХ САНАЛ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн УМС-д хэрэгжилт, гүйцэтгэлийг оруулдаг боловч санхүүжилт олгох процесс нь бүрэн цахимжаагүй тул хариуцсан мэргэжилтэн оруулахад учир дутагдал ихтэй байна. Иймд хяналт хэрэгжүүлэгч, захиалагчийн хяналт болон гүйцэтгэгч компанид санхүүжилт олгох процессыг бүрэн цахимжуулж улсын төсвийн publicinvestment.gov.mn цахим системд холбох. Мөн системд урд оноос дамжин хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг оруулахад иргэдийн санал аваагүй гэсэн төлөвтэй алдаатай харагддаг. Иймд тус системийн хөгжүүлэлтийг сайжруулах шаардлагатай байна.
2. МУЗГ-ын 2010 оны 271 дүгээр "ЖИШИГ ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ (наадмын санхүүжилт)" тогтоолоор Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтооно гэж заасан. Тухайн шийдвэр гарсан хугацаанаас хойш зах зээлийн үнийн өсөлт харьцангуй их болсон тул тус жишиг хэмжээнд өөрчлөлт оруулах нь зүйтэй.
3. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд аймаг, сумын ИТХ, СХДАГ тавих хяналтын талаар заалтыг нарийвчлан оруулах шаардлагатай./бүх ТАХ-д хяналт тавих, бүх сумдыг хамруулан хяналт тавих гэх мэт/. Захиалагчийн хяналтын хувьд нарийвчилсан заалт оруулах-үүрэг даалгавар өгөн, биелэлт хангуулах талаар, хөтлөх маягтыг батлан журамд өөрчлөлт оруулах.
4. Сумдад төсвийг хэт жижиглэн үр нөлөө багатай олон ажлууд төлөвлөн хэрэгжүүлсээр байна. Иймд Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-д өөрчлөлт оруулан энэ талаар хязгаарлалт оруулах, хэрэгжүүлэх ажлын хүрээг нарийн зааж өгөх.
5. Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэн хөнгөлөлттэй үнээр борлуулах, борлуулсан орлогыг ОНХС-д төвлөрүүлэх талаар зохицуулалтыг журамд нарийн тусгах.
6. Төрийн ХАА-ны үнэн зөв байдлыг хангах зорилгоор-Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн хүний оролцоог бууруулах замаар оролцогчдын ерөнхий нөхцөлийг хангасан байдал, оролцогчдын тендерийн давхцал, бүрдлийг хиймэл оюун ухаанаар шалгаж, хуурамч материалыг хянах нөхцөл боломжийг хиймэл оюун ухаанаар магадлах, цахим системийг хөгжүүлэх.
7. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа үнэлгээний хорооны гишүүдийг урамшуулдаг тогтолцоог бий болгох, хүний нөөцийн ажиллах нөхцөл боломжоор хангах.

АЙМАГ, СУМДЫН ИТХ-Д:

1. Журамд ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ гэж заасан ч сумдад төсвийг хэт жижиглэн үр нөлөө багатай олон ажлууд төлөвлөн хэрэгжүүлсээр байна. Иймд сумдад урт хугацаандаа орон нутгийн хөгжилд ач холбогдол бүхий Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан ТАХ-г батлахад анхаарах.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын дарга Т.Нарангарав танаа:

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1-д “орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;” гэсэн заалтын дагуу аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-ийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалттай холбоотой хяналтыг тогтмол хийж, сумдын ИТХ-д чиглэл өгч ажиллах.
- Аймгийн ИТХ-аас аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ-д тавих хяналтыг сайжруулж, иргэдийг мэдээллээр хангаж ажиллах. Хяналтыг хэрэгжүүлэхдээ техникийн тодорхойлолт, батлагдсан зураг, төсвийн дагуу нарийн тулгалтууд хийж, үүрэг даалгавар өгч ажиллах. /тухайн онд хэрэгжиж буй ТАХ-ээс багадаа 50 хувьд нь хяналт тавих/

Засаг дарга О.Пүрэвдорж танаа:

- Аймгийн хэмжээнд нийт 1,376.6 сая төгрөгийн МТТАТ-н авлага 19 суманд бий болсон ба малын тоо толгойн албан татварын бүрдүүлэлттэй холбоотойгоор сумдад хэрэгжихгүй, он дамнасан ажлууд их байгаатай холбоотой авлагыг бууруулах талаар нэгдсэн арга хэмжээ авч ажиллах.
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас ОНХС-н зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд тавих хяналтад хамрагдаж буй сумдын тоог нэмэгдүүлэх.

Сумдын Засаг дарга нарт:

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй бүх ТАХ-д захиалагчийн хяналтыг бүрэн тавих; дутуу, сайжруулах шаардлагатай ажлуудад хугацаатай үүрэг даалгаврыг баталгаажуулан өгөх, биелэлтийг хянах; ажил хүлээлцсэн актад ажил гүйцэтгэсэн, хүлээж авсан хугацааг тодорхой оруулж хэвших. Хяналтын ажлын хэсгийг томилохдоо холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулахад анхаарах. /хяналт тавихдаа техникийн тодорхойлолт, батлагдсан зураг, төсвийн дагуу нарийн тулгалтууд хийх/
- ОНХС-ийн мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангах үүднээс УМС-ийн хөтлөлтийг сайжруулж, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу хариуцах мэдээллийг холбогдох албан тушаалтнууд бүрэн оруулж хэвших.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-үүдийг Нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгуулах, бүртгэлд хяналт тавих
- Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж, хөрөнгийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийн мэдээллийг УМС-д бүрэн, үнэн зөв оруулж, иргэдэд ил тод мэдээллээ хүргэх.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ-д хяналтыг бүрэн тавих. Хяналтаар техникийн тодорхойлолт, батлагдсан зураг, төсвийн дагуу нарийн тулгалтууд хийж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулан ажиллах.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хавсралт-1

№	Сумын нэр	2023			2024			2023, 2024 гүйцэтгэлийн хувь зөрүү	Авлага 2024 оны байдлаар
		Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө /Сумын ИТХ-ын тогтоолоор баталсан дүн/	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь	Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө /Сумын ИТХ-ын тогтоолоор баталсан дүн/	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь		
1	2	3	4	5=4/3*100	6	7	8=7/6*100	9=8-5	10=7-6
1	Арвайхээр	144,000	113,976.50	79.15	132,000	205,147	155	76	73,147
2	Баруунбаян-Улаан	97,078	48,063.90	49.51	156,577	89,334	57	8	(67,243)
3	Бат-Өлзий	177,994	109,815.90	61.7	224,380	84,879	38	(24)	(139,501)
4	Баянгол	354,115	177,877.40	50.23	464,600	180,358	39	(11)	(284,242)
5	Баян-Өндөр	210,275	76,728.00	36.49	278,409	90,585	33	(4)	(187,824)
6	Богд	233,296	187,379.80	80.32	221,974	95,369	43	(37)	(126,606)
7	Бүрд	250,200	91,663.50	36.64	130,554	101,726	78	41	(28,828)
8	Гучин-Ус	123,000	68,587.50	55.76	119,010	83,241	70	14	(35,769)
9	Есөнзүйл	223,400	60,537.90	27.1	242,268	114,093	47	20	(128,175)
10	Зүүнбаян-Улаан	150,312	142,097.70	94.53	231,600	93,589	40	(54)	(138,011)
11	Нарийнтээл	270,008	55,768.50	20.65	309,916	136,699	44	23	(173,218)
12	Өлзийт	70,000	51,022.00	72.89	64,405	50,527	78	6	(13,878)
13	Сант	191,855	131,771.30	68.68	166,568	129,864	78	9	(36,704)
14	Тарагт	124,056	54,498.80	43.93	83,194	78,636	95	51	(4,558)
15	Төгрөг	141,800	124,726.50	87.96	81,500	69,427	85	(3)	(12,073)
16	Уянга	145,000	145,000.00	100	46,000	106,000	230	130	60,000
17	Хайрхандулаан	210,000	131,920.00	62.82	105,500	124,856	118	56	19,356
18	Хархорин	210,000	224,389.30	106.85	243,493	427,457	176	69	183,964
19	Хужирт	80,000	86,596.20	108.25	80,000	112,755	141	33	32,755
Гүйцэтгэлийн дундаж дүн				65.4	Гүйцэтгэлийн дундаж дүн			86.6	

Хүснэгтийн 10-р баганад харагдаж буй хасах дүнтэй буюу МТТАТ-ын авлагатай сумдын нийт дүн нь -1,376.63 сая төгрөг болно.

Хавсралт-2

№	Аймаг, сумын нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Үүнээс:					
				ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд мэдээллийг					
				Бүрэн оруулсан ТАХ-ний		Дутуу оруулсан ТАХ-ний		Огт оруулаагүй ТАХ-ний	
		тоо	Төсөвт өртгийн дүн	тоо	Төсөвт өртгийн дүн	тоо	Төсөвт өртгийн дүн	тоо	Төсөвт өртгийн дүн
0	1	2	3	4	5	6	7	8	9
1	Арвайхээр	19	1,360,438	18	1,315,437.7	1	45,000		
2	Баруунбаян-Улаан	15	498,320	12	395,355.1			3	102,965
3	Бат-Өлзий	27	1,460,351	26	1,391,351	1	69,000		
4	Баянгол	32	848,893	26	713,374			6	135,519
5	Баян-Өндөр	26	712,423	26	712,423				
6	Богд	20	1,200,043	16	1,042,221.1			4	157,821.6
7	Бүрд	11	884,228	11	884,228.4				
8	Гучин-Ус	26	786,735	26	786,735				
9	Есөнзүйл	22	543,067	19	490,067	3	53,000		
10	Зүүнбаян-Улаан	15	478,172	13	458,371.6			2	19,800
11	Нарийнтээл	38	1,183,380	24	948,172	3	37,042.1	11	198,165.4
12	Өлзийт	11	296,126	11	296,126				
13	Сант	17	614,215	15	483,936			2	130,279
14	Тарагт	18	547,886	17	520,692.4	1	27,193.9		
15	Төгрөг	21	999,293	21	999,293				
16	Уянга	31	998,861	23	842,000.0			8	156,861.4
17	Хайрхандулаан	17	556,671	17	556,670.8				
18	Хархорин	16	718,240	15	700,811.4			1	17,428.20
19	Хужирт	16	704,512	13	576,512			3	128,000
	сумын дүн	398	15,391,853	349	14,113,778	9	231,236	40	1,046,840
20	Аймгийн ОНХС	27	8,453,782	3	622,852.3	23	7,811,130	1	19,800
	нийт дүн	425	23,845,636	352	14,736,630	32	8,042,366	41	1,066,640

Хавсралт-3

№	Зөрчлийн утга	Мөнгөн дүн
1	Тарагт сум наадмын талбай 148.9 сая төгрөгөөр, гэрэлтүүлэг камер 47.9 сая төгрөгөөр тус тус бөөн дүнгээр бүртгэсэн	196.82
2	Тарагт сум Соёлын төвийн тайз 36.9 сая төгрөгөөр бөөн дүнгээр бүртгэсэн	36.94
3	Жаргалант багийн 20.0 сая төгрөгийн камержуулалт бөөн дүнгээр бүртгэсэн	20.00
4	Зүүнбаян-Улаан бизнес хөгжлийн төвийн засвар ор, сандал зэрэг тавилгыг 10.0 сая төгрөг бөөн дүнгээр бүртгэсэн	10.00
5	Бат-Өлзий дуусаагүй ТАХ-үүдийг дуусаагүй барилга дээр бүртгэсэн	
6	Бат-Өлзий наадмын талбайн засвар 188,3 сая төгрөг бөөн дүнгээр орлогот бүртгэсэн	188.35
7	Бат-Өлзий сумын Бизнес хөгжлийн төв, түрээсийн байрны засвар 10.0 сая төгрөгийн дотор заслыг сайжруулалтаар бүртгэсэн	10.00
8	Хужирт ЭМТ 22.9 сая төгрөгийн генераторыг буруу дүнгээр орлогот авсан, ЗДТГ 19.0 сая төгрөгийн генератор орлогот аваагүй	41.90
9	Хархорин Нийтийн эзэмшлийн камержуулалт 15.9 сая төгрөгийн урсгал зардлыг хасаж бүртгээгүй	15.87
10	Хархорин 4-р багийн гүүр барих 4.9 сая төгрөг капиталжуулах, Ухаалаг худгийн цахим төхөөрөмж 20.9 сая төгрөг 2ш худгийн төхөөрөмжийг орлогот авсан боловч 2ш нөөцийг савыг огт бүртгээгүй салгаж бүртгэх	25.89
11	Баянгол ЕБС, цэцэрлэг 33,0 сая төгрөгийн камерыг ИТХ тогтоолд оруулаагүй тул бүртгэлд аваагүй	33.00
12	Баянгол цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын талбайн тохижилт 18,9 сая төгрөгийн тоног төхөөрөмж бөөн дүнгээр бүртгэсэн	18.96
13	Гучин-Ус Аргалантбагийн төв шинээр барьсан 36.0 сая төгрөгийн барилгыг хуучин багийн төвийн барилга дээр капиталжуулан бүртгэсэн байна	36.00
14	Гучин-Ус Лед дэлгэц 50,0 сая төгрөг ЗДТГ дээр бүртгэсэн боловч Соёлын төв ашиглаж байна	50.00
15	Гучин-Ус Цэцэрлэгт хүрээлэн хүүхдийн тоглоомын талбайн тохижилт 29.0 сая төгрөг капиталжуулах байсныг тоглоомыг шинээр орлогот бүртгэсэн	29.02
16	Төгрөг гэрэлтүүлэг камер 83.9 сая төгрөг засвар хийсэн дүнг хасаж шинээр нэмэгдсэн гэрэлтүүлэг камерыг нэг бүрчлэн орлогот авахгүй бөөн дүнгээр бүртгэсэн	83.89
17	Төгрөг Наадмын талбайг тохижилт спорт албай тохижуулах 126.9 сая төгрөгийн нийтийн ОО-г салгаж бүртгээгүй бөөн дүнгээр капиталжуулсан байна Жишээ нь: нийтийн ОО, зөөврийн тайз, хиймэл зүлэг, хогийн сав	126.99
18	Богд ЕБ-ын 1 дүгээр сургууль Бага сургуулийг зөөж хөл бөмбөгийн талбай барих 66.7 сая төгрөгийг Хөл бөмбөгийн талбай, сагсны талбайг бүртгэхдээ өмнөх бага сургуулийг буулгасан зардлыг хасаагүй бүх дүнгээр бүртгэсэн байна	66.74
19	Богд 2-р цэцэрлэг сүүдрэвч 4.5 сая төгрөг, сүүдрэвчний шал 2.4 сая төгрөг гэж тус тусад нь бүртгэлд авсан, 140м2 лего шал 9.2 сая төгрөгөөр бөөн дүнгээр бүртгэсэн байна	16.10
20	Богд ЕБ-ын 1 дүгээр сургууль пилта 6.1 сая төгрөг, угаалтуур 2.0 сая төгрөг, суултуур 2.8 сая төгрөгийн урсгал засварыг хөрөнгөд бүртгэсэн	10.92
21	Хайрхандулаан ЕБС үдийн цайны тоног төхөөрөмж 46.1 сая төгрөгийн хөрөнгийг зах зээлийн үнээр бүртгээгүй нийлүүлэгч компанийн үнийн дүнгээр бүртгэсэн	46.10
Нийт дүн		1,063.49

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/18

Арвайхээр сум

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, аудитаар тогтоосон албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Ө.Ринчинмядаг)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллан, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга (Т.Нарангарав), аймгийн Засаг дарга (О.Пүрэвдорж), сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Мөнхбат), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Т.Ариунболд), Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Цэдэнбалжир), Худалдан авах ажиллагааны газрын дарга (Ц.Болдбаатар) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер (П.Хорлоосүрэн), ахлах аудитор (Ө.Ринчинмядаг) нарт даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Д.Очирбат)-д үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

6225010052

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны 8 дугаар сарын 01-ний А/18 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

6217143681
ИМОН0059 9044094

№	Зөрчлийн товч утга	Хариуцах байгууллагын нэр	Мөнгөн дүн /сая.төг/
1	- Арвайхээр суманд хийгдсэн 693.0 сая төгрөгийн Эко нойлын ажил бодит байдал дээр 38.0 хувийн гүйцэтгэлтэй буюу 266 эко нойл хийхээс 102-г хийсэн байхад 64.0 хувь буюу 446.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон, гүйцэтгэл дутуу байхад Арвайхээр хотын Захиргааны албаны менежер гарын үсэг зурж 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ажлын гүйцэтгэлийн актыг баталгаажуулсан байна. - Арвайхээр сумын цэцэрлэгт хүрээлэнгүүдэд тохижилт хийх 896.0 сая төгрөгийн ажил бодит байдал дээр 60.0 хувийн гүйцэтгэлтэй байхад 725.9 сая төгрөг буюу 80.0 хувийн санхүүжилт олгосон, гүйцэтгэл дутуу байхад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, Барилга, хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн гарын үсэг зурж 2025 оны 5 дугаар сарын 19-ний өдөр ажлын гүйцэтгэлийн актыг баталгаажуулсан зөрчил илэрсэн байна. - Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй 71.0 сая төгрөгийн Хархорин сумын Туурийн хамгаалалтын хашааны ажил 2022 оны 9 дүгээр сараас хойш хийгдэж байгаа ажил нь гэрээнд заасан хугацаандаа хийгдээгүй, дутуу, чанаргүй, тоо хэмжээ зөрүүтэй байна. - Аймгийн ОНХС-аас хийгдсэн “Хас гарьд” ХХК-ийн гүйцэтгэсэн Төв бараан захын авто зам шинэчлэл 209.6 төсөвт өртөгтэй ажлын явган хүний зам тоо хэмжээ зөрүүтэй байна. - Аймгийн ОНХС-с хийгдсэн Арвайхээр сумын Авто замын уулзварын өргөтгөл хийх “Хас гарьд” ХХК-ийн гүйцэтгэсэн 350.0 сая төгрөгийн ажил ус зайлуулалт шийдээгүй ус их хэмжээгээр тунасан. - Бат-Өлзий сумын 3 өргөн чөлөөний зам засах ажил “Анда Рөүд” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн нийт 798.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй (сумын ОНХС-с 400.0 сая төгрөг төсөвлөсөн) боловч чанар муу хийгдсэн байна. Зам дээр ус их хэмжээгээр тогтдог, олон тооны нүх үүссэн, гэрээний хугацаандаа дуусгаагүй, хүлээж аваагүй байна. - Аймгийн ОНХС-с баяр наадмын зардалд 55.1 сая төгрөг зарцуулсан нь жишиг хэмжээ болох 10.0 сая төгрөгөөс хэтэрсэн байна.	Аймгийн ОНХС	1447.2
2	- Аймгийн ОНХС-аас 2024 онд хийгдсэн “Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Арвайхээр сумын гэр хорооллын айл өрхүүдэд нийлүүлэх сайжруулсан шахмал түлшний үнийн зөрүү олгох” 340.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил нь Агаарын бохирдол буурч 35725 иргэнд өгөөжөө өгнө гэсэн төлөвлөлттэй байсан боловч зорилтот түвшиндээ хүрээгүй. Мөн анхан шатны баримт, тооцоо, судалгаа, тайлан бүрэн бус байхад “Баянтээг түлш” ХХК-ийн санхүүжилт хүссэн албан тоотыг үндэслэл болгон шилжүүлэг хийсэн байна. - Тог цахилгааны асуудал шийдэгдээгүй байхад баригдсан “Баянгол суманд мал нядалгааны цех байгуулах” 79.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил ашиглалтгүй байна.	Аймгийн ОНХС	419.5
3	Хужирт суманд “Отгоннинж” ХХК-ийн 2021 онд барьж эхэлсэн 674.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Төрийн албан хаагчийн орон сууцны ажил дуусаагүй, зогсонги байдалтай хэвээр байна.	Аймгийн ОНХС	759.0

	НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх Олон улсын сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн санхүүжилтээс 59.5 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс 25.5 сая төгрөгөөр “Хужиртад үйлдвэрлэв” дэлгүүрийг барих ажлыг “Отгон нинж” ХХК гүйцэтгэсэн бөгөөд сум чанаргүй хийгдсэн гээд хүлээж аваагүй, одоо болтол ашиглалтгүй байна.		
4	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй Арвайхээр Гэндэнгийн гудамж явган хүний замын засварын зураг төсөв 19.8 сая төгрөг, БОЭТ-ийн халдвартын эмнэлгийн гадна фасадын засвар 172.7 сая төгрөг, Цэргийн ангийн халаалтын зуухны өргөтгөл, шинэчлэл 100.0 сая төгрөг, БОЭТ-ийн төрөх эмэгтэйчүүдийн эмнэлгийн гадна фасадын засварын зардал 346.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 4 төрлийн 639.28 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөн баталсан байна.	Аймгийн ОНХС	639.3
5	Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр 2024 онд бий болсон 1,011.5 сая төгрөгийн хөрөнгийг зөрүүтэй дүнгээр бүртгэж, 52.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй байна.	Аймгийн ОНХС	1063.5
6	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 27 ТАХ-ээс 23 ТАХ-ний мэдээллийг дутуу оруулсан, 1 ТАХ-ний мэдээллийг удирдлагын мэдээллийн системд огт оруулаагүй зөрчил илэрсэн.	Аймгийн ОНХС	0
7	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд баригдсан 179.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Уянга сумын мал нядалгааны цехийн зарим ажлууд дуусаагүй, ашиглалтгүй, өмнөх онд өгсөн зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.	Аймгийн ОНХС	179.6
8	“Орон сууцны гадна фасадын засвар”-ын шугам засварын 29.2 сая төгрөгийн ажлын 4-р багц Арвайхээр сум 127-р байр шугам засвар 9.6 сая төгрөг, 5-р багц Арвайхээр сум 5, 13, 14-р байр шугамын засвар 19.6 төгрөг болгож шууд гэрээ байгуулсан; 1, 2, 3-р багцын 318.5 сая төгрөгийн ажилд оролцогчийг шалгаруулахдаа ТШЗ 19.1.2. Үндсэн тоног төхөөрөмж, машин механизмийн шаардлагыг бүрэн хангахгүй оролцогчийг шалгаруулсан. “Арвайхээр сумын гудамж талбай, сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны камержуулалтыг нэмэгдүүлэх” 332.8 сая төгрөгийн ажилд камер бичигчийг JUAN 6216N үйлдвэрлэгчийн нэр заасан. “Арвайхээр сумын цэцэрлэгт хүрээлэнгүүдэд тохижилт хийх” 900.0 сая төгрөгийн ажлын баримт бичигт түншлэлээр орсон тохиолдолд гишүүн тус бүр хангах шаардлагыг зааж өгөөгүй байна. “Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд унтуулгын аппарат авах” 80.0 сая төгрөгийн ажилд нээлттэй тендерийн аргаар оролцогч шалгаруулж зөвлөмж гаргахдаа шийдвэрийг үнэлгээний хороо ажлын 22 хоногт гаргасан. “Арвайхээр сумын авто болон явган хүний зам, гэрэл дохио, гэрэлтүүлгийг засварлах” төсөл, арга хэмжээний 1, 3, 4, 5 -р багц 2,100.0 сая төгрөгийн ажилд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан шаардлага хангаагүй байхад сонгон шалгаруулсан. “Арвайхээр сумын авто болон явган хүний зам, гэрэл дохио, гэрэлтүүлгийг засварлах” ажлын 2-р зарлалаас хурлаар хэлэлцээгүй Машин, механизмын шаардлагыг хассан. “Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсийн холбооны худаг сувагчлалын ажил” -ийн 3-р зарлалаас хурлаар хэлэлцээгүй Хүний нөөц болон Тоног төхөөрөмжийн шаардлагыг өөрчилсөн, “Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн төрөх, эмэгтэйчүүдийн эмнэлгийн гадна фасадын засвар”-ын ажилд Үнэлгээний хорооны хурлаар оролцогчид тавигдах шаардлага, зарлал, урилга хэлэлцсэн тухай хурлын тэмдэглэл байхгүй байна.	Аймгийн ОНХС	2762.96
9	Арвайхээр суманд хийгдэж буй 693.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эко нойл” төсөл хэрэгжүүлэх ажил нь зориулалт бус зарцуулалт бөгөөд иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэгийн шинжтэй, суурилуулсан нойлууд нь газарт суулт өгсөн, хаяавч шороо цөмрөлттэй, бэхэлгээ муу тул зарим нойлын дээд бүхээг салхинд унаж салсан, нойлын нүх ухан орхиж дээд бүхээг хийхгүй удсанаас иргэдэд хүндрэлтэй, эрсдэлтэй байдал үүсгэсэн, чанаргүй ажил бөгөөд	Арвайхээр ОНХС	289.5

	гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй байна. Тус ажлын гүйцэтгэл 38.0 хувь буюу 266 эко нойл хийхээс 102-г хийсэн байхад 64.0 хувь буюу 446.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон, гүйцэтгэл дутуу байхад Арвайхээр хотын Захиргааны албаны менежер гарын үсэг зурж 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ажлын гүйцэтгэлийн актыг баталгаажуулсан зөрчил илэрсэн. - Арвайхээр суманд хийгдсэн 44.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ховд Сафари” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлаар хийсэн торон хайс болон шон чанар муу байна. “Мандах төгс гурван эрдэнэ” ХХК-ийн багуудад хийж гүйцэтгэсэн 6 хүүхдийн тоглоомын талбай засварлах, тохижуулах 77.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын засварын хугацаа сунгаснаас шалтгаалж эхний хийгдсэн ажлууд эвдрэл үүссэн байна.		
10	Арвайхээр сум орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлахдаа иргэдийн санал авсан боловч ач холбогдлоор нь өндөр санал авсан төсөл, арга хэмжээгээр нь эрэмбэлэгдээгүй хог тээврийн машин, нийтийн тээврийн автобусны тоог нэмэгдүүлэх, Өндөргэгээн Занабазарын музейг завсарлах, зураг төсөв хийлгэх 2 төрлийн 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг төлөвлөж баталсан байна.	Арвайхээр ОНХС	250.0
11	Арвайхээр сумын багуудын иргэдийн ирц хангалтгүй, хүчин төгөлдөр бус ирцтэй байхад хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэн, эрэмбэлж баталсан байна.	Арвайхээр ОНХС	0
12	“Хутагт- Уулын өгөөж” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй 69.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй багуудад худаг, цооног гаргах ажил нь гүйцэтгэгч компанийн тоног төхөөрөмж эвдэрсэн гэх шалтгаанаар ажил удааширч, гэрээний хугацаандаа хийгдээгүй байна. “Есөн бор-Өндөр” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 188.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй наадмын талбайг засварлан 2 давхар болгох, наадмын талбай руу тог татах ажил нь хийгдэж дуусаагүй байхад бүрэн санхүүжилт өгсөн, чанар байдлын хувьд тааруу, техникийн тодорхойлолтоос зөрүүтэй - угаадаг замаск хууларсан, төв асрын 2 давхрын сандал 2 эгнээ байхаас 1 эгнээ, арын хаялаг богино болон бусад зургаас зөрүүтэй ажлууд хийгдсэн зэрэг зөрчилтэй ажлууд байна.	Бат-Өлзий ОНХС	257.8
13	- Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хатуу эдлэл” худалдан авах 40.65 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд нийлүүлсэн хатуу эдлэл эвдрэл ихтэй, төмөр орны холболт салсан, шүүгээний доод тавцан салсан байна. “Наадмын төв талбайн засвар, 2 давхар болгох, наадмын талбай руу тог татах” ажилд хийгдсэн 7ш ЭКО нойлоос дээвэргүй 1, хаалгагүй 2 нойл байгаа нь хөрөнгийн хадгалалт, хамгаалалтгүй муутай байна.	Бат-Өлзий ОНХС	40.65
14	Эрүүл мэндийн төвийн шүдний кабинет тохижуулах 19.8 сая төгрөгийн ажлыг хүлээн авсан боловч шүдний сандлын хүчин чадал, даац техникийн тодорхойлолтоос зөрүүтэй, шүдний эмч байхгүй тул ашиглалтгүй байна.	Баянгол ОНХС	19.8
15	- Баянгол сумын “ЕБС, СӨББ, Спорт заалны хяналтын камер шинэчлэх” 33.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд дүрс бичигчийг JUAN NVR үйлдвэрлэгчийн нэр заасан. “Ахмадын өргөөний барилгын дотор засвар (Халаалтын шугам, Ариун цэврийн өрөөг тохижуулах)” 35.0 сая төгрөгийн ажилд оролцогчид тавигдах шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлыг үнэлгээний хороогоор хэлэлцэх байтал нарийн бичигт үүрэг болгосон. “Гүн өрмийн худаг шинээр гаргах, Өндөр-Өнц, Хаяа баг”, “Сумын түүхт ойг угтсан бүтээн байгуулалтын ажил”, “ЕБС, СӨББ, Спорт заалны хяналтын камер шинэчлэх”, “Ахмадын өргөөний барилгын дотор засвар (Халаалтын шугам, Ариун цэврийн өрөөг тохижуулах)” ажлуудад ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг хугацаанд нь гаргуулаагүй байна.	Баянгол ОНХС	33.6
16	“Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургуулийн спорт заалны хяналтын камер шинэчлэх” 33.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил нь хяналтын камерыг суурилуулахдаа гар хүрэх өндөрт суулгаснаас	Баянгол ОНХС	33.0

	болж камерын харах чиглэлийг өөрчилдөг нь ашиглалт бүрэн бус байдал бий болдог, спорт заалны камерыг хамгаалалтгүй суулгаснаас камерыг бөмбөгөөр онож эвдэх, хүүхдийн хувцас солих өрөөнд камер суурьлуулсан нь хүүхдийн эрх зөрчих эрсдэлтэй байна.		
17	- Батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ иргэдийн саналгүй ажлыг дотор нь шингээн хийж Ус сувгийн их засварын ажлаас сумын ЗДТГ-т 18.9 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан. - ЕБС-ийн дотуур байрны хатуу зөөлөн эдлэл нийлүүлэх, засварын ажилд нэмэлт гэрээгээр 13.0 сая төгрөгөөр 2 байранд дүш хийгдсэн бөгөөд шугам бөглөрөн дүшнээс доош ус алдан тааз, хана нэвчсэн. - Сумын төвийн гэр хорооллын тохижилт хаягжуулалтын 45.0 сая төгрөгийн ажил хийгдэж дуусаагүй байхад хүлээн авсан байна.	Богд ОНХС	76.95
18	Морины их шүтээний засвар, талбайн тохижилтын ажилд 30.0 сая төгрөгийг (хөшөө, дурсгалын шинжтэй) зориулалт бусаар зарцуулсан байна.	Богд ОНХС	30.0
19	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхээр 3000 боодол ногоон тэжээл, 1600 шуудай орос хивэг нөөцлөн бэлтгэсэн нийт 35.6 сая төгрөгийн 2000 боодол ногоон тэжээл хөгцөрч харлан муудсан (ногоон тэжээл өвөл хөлдүү, нойтон ирдэг) байна.	Богд ОНХС	35.6
20	"Сумын төвийн чиглэлийн камержуулалт"-ын 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлаар нийт 52 ширхэг хяналтын камер хийгдсэнээс нийтийн эзэмшлийн газрын чиглэлийн-6, PTZ-1 камер ажиллахгүй байна.	Богд ОНХС	45.0
21	"Их угалз" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Гучин-Ус сумын Ахмадын өрөөг засварлах ажлын дэвэрээс ус гоожсон асуудал шийдэгдээгүй, дусаал гоожсон байдалтай байна. - Баяр наадмын зардалд 14.6 сая төгрөг зарцуулсан нь журамд заасан жишиг хэмжээнээс хэтэрсэн байна	Гучин-Ус ОНХС	22.6
22	"Хөдөлмөр зуслангийн вэб сайт хийх" 5.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил нь www.nomadiceducation.mn сайтад мэдээлэл оруулсан гэх боловч, үр дүн тооцох боломжгүй, дутуу хийгдсэн байна.	Есөнзүйл ОНХС	5.0
23	"Бага хайлантай" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 142.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Төрийн албан хаагчдын орон сууцны барилгын ажлын дэвэрийн дулаалга муу, дусаал гоождог, агааржуулалт буруу хийгдсэн, ус дусдаг, дэвэрээс дулаан алддаг, дотор ханад цуурал өгсөн, гадаа хаяавч хийгдээгүй, бохирын кольцоог байшингийн өндөр талд суулгасан тул бүрэн дүүргэх боломжгүй, ажлын даалгаварт 100м гүний худаг өрөмдөж насос тавих ажил байсныг өөрчилж төвийн цэвэр усны шугамд холбосон байна. "Сод-Ээл" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 49.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сумын 22 айлын орон сууцны засварын ажил нь дэвэрийн ажил дутуу хийгдсэн (олон жил борооны усанд норж дагтаршсан дэвэрийн дулаалгын хэсгийг бүрэн хатаахгүйгээр дэвэрийг сольсон) таазнаас дусаал гоождог, тамбарна будаг урсаж, дусаал гоожсон, дэвэрийн унь модыг банзаар битүүлэх ажил хийгдээгүй байна.	Зүүнбаян-Улаан ОНХС	192.5
24	- Зүүнбаян-Улаан сумын "22 айлын орон сууцны засвар" 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд Санхүүгийн тайланд аудит хийлгэсэн байх гэсэн боловч цахим системд оруулахдаа хассан. 2-р зарлалаас хурлаар хэлэлцээгүй Агааржуулалтын бөглөрсөн хэсгийг гаргаж, гадагш гаргах ажлыг хассан байна. "Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, гамшгаас хамгаалах", "Төрийн албан хаагчдын орон сууц" зэрэг ажлуудын ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг хугацаанд нь гаргуулаагүй байна.	Зүүнбаян-Улаан ОНХС	50.0
25	Нарийнтээл сумын Өндөр хөмөг багийн төвийг засварлах ажлыг "Арвайн хийц" ХХК 32.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэхдээ Сагс, волейболын талбайг 30м урт, 18м өргөн, 10см-с багагүй зузаантай байх цутгах гэж заасан боловч тулгалтаар үзэхэд 30м урт, 9м өргөн, 5см зузаантайгаар буюу цутгалтын ажлыг 25.0 хувийн гүйцэтгэлтэй хийсэн байхад техникийн шаардлага бүрэн хангасан гэж үзээд комисс хүлээж авсан байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний налуу замыг стандартын бус хийсэн.	Нарийнтээл ОНХС	46.8

	• Баяр наадмын зардалд 14.9 сая төгрөг зарцуулсан нь журамд заасан жишиг хэмжээнээс хэтэрсэн байна		
26	“Төрийн албан хаагчдын орон сууц” барих 188.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг инженерийн шугамын ажил шийдэгдээгүй байхад хэрэгжүүлсэн нь ашиглалтгүй болох эрсдэлтэй байна.	Нарийнтээл ОНХС	188.35
27	Худгийн цооног ухуулах” 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 15.0 сая төгрөгөөр 3 хувааж 1, 2, 4-р багт худгийн цооног ухуулах ажил болгож шууд худалдан авалт хийсэн байна.	Өлзийт ОНХС	45.0
28	“Гэр хороолол руу дулааны шугам оруулах” 291.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил гэрээний хугацаандаа хийгдээгүй, усан хангамж хангалтгүй байгаа нь ашиглалтгүй болох эрсдэлтэй байна.	Сант ОНХС	291.7
29	“Майханы арын хүүхдийн тоглоомын талбай” 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд Үнэлгээний хорооны хурлаар оролцогчид тавигдах шаардлагуудыг хэлэлцээгүй байна.	Сант ОНХС	40.0
30	“Ткон констракшн” ХХК-ийн 143.9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн Наадмын талбай барих ажлын саравчууд бэхлэгээ чанар муу, 8 лед гэрэл хийгээгүй, тог цахилгааны асуудал шийдэгдээгүй байхад гэрэлтүүлгүүд хийгдэхээр заасан, төв асрын урдах төмөр хашлага байхгүй, төв асар болон үзэгчдийн асрын материалыг өөрчилсөн зэрэг зөрчлүүд илэрсэн байна.	Тарагт ОНХС	143.9
31	“Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гаднах хүүхдийн тоглоомын талбай тохижуулах” 11.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тоглоомын бэхлэгээ чанаргүй, аюулгүй байдлыг хангаж, сайжруулах шаардлагатай байна.	Тарагт ОНХС	11.3
32	Тарагт сумын “Гэрэлтүүлэг камертай” 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний хяналтын камерыг UNIVIEW IPC635SR-X33DU-DT гэж үйлдвэрлэгчийн нэр заасан байна.	Тарагт ОНХС	50.0
33	- Спортын талбай тохижуулах “Баянсүвд-Эрдэнэ” ХХК-ийн гүйцэтгэсэн 127.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын нийтийн бие засах газрын зарим эд хогшил дутуу, цонхны хэмжээ зөрсөн, сур харвааны талбайн цутгалт нимгэн, хайсан хашаа өндрийн хэмжээ зөрүүтэй байна. - Сумын төвийн камер, гэрэлтүүлэг “Баянсүвд-Эрдэнэ” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 83.9 сая төгрөгийн ажлын хийгдсэн шонгийн диаметр хүрэхгүй, 30ш камераас 26ш камер ажиллахгүй байгаа зөрчил илэрсэн.	Төгрөг ОНХС	210.9
34	- Төгрөг сумын “Тэжээлийн нөөц бүрдүүлэх” 54.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын 18.0 сая төгрөгөөр хивэг, 18.0 сая төгрөгөөр өвс, 18.0 сая төгрөгөөр хүчит тэжээл худалдан авах гэж 3 хувааж шууд худалдан авсан, “Сумын лед дэлгэцтэй болох” 68.0 сая төгрөгийн ажилд дүрсний дамжуулагчийг NOVA STAR VX6S гэж үйлдвэрлэгчийн нэр заасан байна.	Төгрөг ОНХС	122.0
35	“Цэцэрлэгт хүрээлэн нийтийн эзэмшлийн хайс болон зам талбайн тохижилт хийх” ажлаар худалдан авсан 4.5 сая төгрөгийн үнэ бүхий өвс пресслэгч машин ашиглалтгүй байна.	Төгрөг ОНХС	4.55
36	- Худалдан авах ажиллагааг 2023 онд зохион байгуулж, 2024 онд хүлээн авсан “Хадлангийн зориулалттай иж бүрэн техник, тоног төхөөрөмж худалдан авах” 60.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмжид нийлүүлэгдсэн 50 морины хүчин чадалтай трактор нь дагалдах тоног төхөөрөмжөө дийлдэггүй, хүлээн авснаас хойш нэг хүнд түрээсэлж, ашиглалт хангалтгүй байна. “Цэцэрлэгт хүрээлэн нийтийн эзэмшлийн хайс болон зам талбайн тохижилт хийх” ажлын дагуу худалдан авсан 4.5 сая төгрөгийн үнэтэй өвс пресслэгч машин ашиглалтгүй байна.	Уянга ОНХС	60.6
37	“Нийтийн ариун цэврийн газар байгуулах” 79.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил хийгдсэн боловч төвийн инженерийн шугамд холбоогүй тул ашиглалтгүй байна. - Уянга сумын 5-р багийн Ногоон булгийн эхэнд худаг гаргах 18.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Аум алт” ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд нэг насос дутуу хүлээлцээгүй, гэрээний хугацаандаа дуусаагүй байна.	Уянга ОНХС	98.2

38	- ЕБС-ийн үдийн цайны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, сайжруулах ажлын зардлаас Цэцэрлэгт 7.0 сая төгрөгийн дроз, дэвсгэр худалдан авах иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй ажил хийсэн байна. - Цахим сургалт, мэдээллийн өрөө тохижуулах ажил нийлүүлэгдсэн тоног, төхөөрөмжийг тулгахад өндөр нягтралтай 2.3 сая төгрөгийн "Хурлын камер" дутуу байна. - Нийтийн амралт хүндэтгэлийн талбайтай болох 72.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил гэрээний хугацаанд дуусаагүй байна	Хайрхандулаан ОНХС	83.65
39	Орхон багийн төвийн барилга засварлах 20.0 сая төгрөгийн ажил техникийн шаардлага хангаагүй, чанаргүй хийгдсэн ажлыг комисс хүлээж авсан, (паркетин шал хийгдсэн боловч хөөрч, нумарсан, дээвэрт ОСП хавтангаар дотор дээвэрлэлт хийх байсан боловч дутуу хийсэн, өргөтгөж барьсан хананы дагуу ус, дусаал гоождогоос болж ашиглах боломжгүй) байна.	Хархорин ОНХС	20.0
40	"Хадлангийн талбай хаших" 62.3 сая төгрөгийн ажлаар худалдан авсан хашаа бүрэн ашиглалтгүй, агуулахад хураалттай байдалтай байна.	Хархорин ОНХС	62.34
41	Сумын 2-р цэцэрлэгийн хүнсний агуулах 19.6 сая төгрөгөөр 2023 онд баригдсан боловч чанар муу болсон тул гүйцэтгэгч компаниар дахин засвар хийлгэж ашиглалтад оруулаагүй байна.	Хужирт ОНХС	19.6
42	"Шикдеко" ХХК-ийн нийлүүлсэн нийт 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Соёлын төвийн урлагийн хувцасны 14.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын бүжгийн хувцас чанар байдал муу, барилгын дээврээс дусаал гоожсоноос LED дэлгэцийн нэг нүд дэлгэц шатсан байна	Хужирт ОНХС	14.65
43	Хужирт сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй Бизнес хөгжлийн төвийн засвар 37.044 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг төлөвлөж баталсан байна.	Хужирт ОНХС	37.0
Нийт мөнгөн дүн			10,203.6

